



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН
ТУШААЛ

2020 оны 08 сарын 20 өдөр

Дугаар А/71

Улаанбаатар хот

Аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/70 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт”-д хийсэн нийцлийн аудитын тайланг нэгдүгээр хавсралтаар, аудитаар өгсөн албан шаардлагын жагсаалтыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталгаажуулсугай.
2. Аудитын тайланг Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороо, Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Сангийн яаманд тус тус хүргүүлсүгэй.
3. Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, үр дүнг 2020 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Монгол Улсын Ерөнхий сайд /У.Хүрэлсүх/, Сангийн сайд /Ч.Хүрэлбаатар/ нарт зөвлөсүгэй.
4. Аудитын тайлан, ажлын баримтыг 2020 оны 9 дүгээр сарын 15-ны өдрийн дотор Үндэсний аудитын газрын архивд шилжүүлж, аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Үндэсний аудитын газрын Нийцлийн аудитын газар /С.Энхбаатар/-т даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОРЫН
ОРЛОГЧ БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР




О.ТЭНГИС



МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

“Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт”-д хийсэн нийцлийн аудитын тайлан



Шилэн дансны тухай хуулийг боловсронгуй болгох ажлыг эрчимжүүлэх шаардлагатай байна.

Улаанбаатар хот
2020 он



Агуулга

<p>Тайланг бэлтгэсэн: YAГ-ын Нийцлийн аудитын газар</p> <p>НАГ-ын захирал бөгөөд Тэргүүлэх аудитор <i>С.Энхбаатар</i></p> <p>Аудитын менежер <i>Х.Болдбаатар</i></p> <p>Ахлах аудитор <i>Д.Отгонбаяр</i></p> <p>Аудитор <i>С.Сугармаа В.Орхон Ч.Бумдарь</i></p> <p>2020 оны 06 дугаар сар</p> <p>Тайланг YAГ-ын веб сайт-аас үзнэ үү. www.audit.mn Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 261729 дугаарын утас, 260949 дугаарын факсаар харилцана уу.</p> <p>Хаяг: Үндэсний аудитын газар, Засгийн газрын 4 дүгээр байр, Бага тойруу-3, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар 15160, Монгол улс</p>	<p>Агуулга 3</p> <p>Товчилсон үгийн жагсаалт 4</p> <p>Аудит хийх үндэслэл..... 5</p> <p>Аудитын зорилт..... 5</p> <p>Аудитын хамарсан хүрээ..... 5</p> <p>Аудитын арга зүй..... 5</p> <p>Аудитад ашигласан шалгуур үзүүлэлт 6</p> <p>Үндсэн мэдээлэл..... 7</p> <p>БҮЛЭГ 1 ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН 3 ДУГААР ЗҮЙЛИЙН 3.1.1, 3.1.2-Т ХАМААРАХ БАЙГУУЛЛАГУУД ХУУЛЬД ЗААСАН ХУГАЦАА ХОЦРООЖ МЭДЭЭЛЛЭЭ ИЛ ТОД БАЙРШУУЛДАГ ЗӨРЧИЛ ХЭВЭЭР БАЙНА..... 8-15</p> <p>1.1. Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, төрийн өмчит үйлдвэрийн газрууд хуульд заасан хугацаа хоцроож мэдээллээ байршуулж байна..... 8-12</p> <p>1.2. Орон нутгийн төсөв, түүний төсвийн захирагчид шилэн дансны мэдээллийг байгууллагын мэдээллийн самбартаа байршуулах чиг үүргийн хэрэгжилтийн байдал 13</p> <p>1.3. Санхүү төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын хууль заасан чиг үүргийн хэрэгжилтийн байдал.... 13-15</p> <p>БҮЛЭГ 2. ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН 3 ДУГААР ЗҮЙЛИЙН 3.1.4 -3.1.5 -Д ЗААСАН БАЙГУУЛЛАГУУД ШДНЦХ-Т БҮРЭН ХАМРАГДАХГҮЙ ХЭВЭЭР БАЙНА..... 16-21</p> <p>2.1. Шилэн дансны тухай хуулийн 3.1.3-т заасан ТӨОХК, ОНӨОХК-ууд ШДНЦХ-т бүрэн хамрагдаагүй байна..... 16-17</p> <p>2.2. Шилэн дансны тухай хуулийн 3.1.4-т заасан ААНБ-уудын хувьд хуулийн хэрэгжилт хангалтгүй хэвээр байна..... 18-19</p> <p>2.3. Төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгчид хууль заасан мэдээллийг бүрэн мэдээлээгүй байна..... 20-21</p> <p>БҮЛЭГ 3. ШИЛЭН ДАНСНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ОРОН НУТГИЙН ИТХ, ИНХ ХУУЛЬД ЗААСАН ХЯНАЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛДЭГГҮЙ ХЭВЭЭР БАЙНА..... 22-24</p> <p>3.1. Хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт заасан бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, иргэдийн Нийтийн Хурал холбогдох хяналтыг бүрэн хэрэгжүүлээгүй байна..... 22-23</p> <p>3.2. Өмнөх аудитуудаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байна 23-24</p> <p>Дүгнэлт 25</p> <p>Зөвлөмж 26</p> <p>Хавсралт-1 27</p> <p>Хавсралт-2 28-32</p> <p>Холбогдох байгууллагын санал 33</p> <p>Албан шаардлагын жагсаалт..... 34-35</p>
--	--



Товчилсон үгийн жагсаалт

ААНБ	Аж ахуйн нэгж, байгууллага	ШЕЗ	Шүүхийн ерөнхий зөвлөл
АТГ	Авилгатай тэмцэх газар	ТАБ	Төрийн аудитын байгууллага
АДБОУС	Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт	ТАЗ	Төрийн албаны зөвлөл
БОАЖС	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд	ТББ	Төрийн бус байгууллага
БЗД	Баянзүрх дүүрэг	ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
БХБС	Барилга, хот байгуулалтын сайд	ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
БХС	Батлах хамгаалахын сайд	ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
БСШУС	Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд	ЧД	Чингэлтэй дүүрэг
ГХС	Гадаад харилцааны сайд	УДШ	Улсын дээд шүүх
ЗГХЭГ	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар	УИХ	Улсын Их Хурал
ЗТХС	Зам, тээврийн хөгжлийн сайд	УУХҮС	Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд
ЕТГ	Ерөнхийлөгчийн Тамгын газар	ҮАБЗ	Үндэсний аюулгүй байдлын зөвлөл
ИНХ	Иргэдийн Нийтийн Хурал	ҮАГ	Үндэсний аудитын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	ҮСХ	Үндэсний статистикийн хороо
МБ	Монгол банк	ҮХЦ	Үндсэн хуулийн цэц
МУ	Монгол улс	ТГ	Тамгын газар
НАГ	Нийцлийн аудитын газар	ТНБД	Төрийн нарийн бичгийн дарга
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар	ТӨААТҮГ	Төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНӨҮГ	Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар	ХНХС	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд
ОНӨХК	Орон нутгийн өмчит хувьцаат компани	ХЗДХС	Хууль зүй, дотоод хэргийн сайд
ОНӨОХК	Орон нутгийн өмчийн оролцоотой хувьцаат компани	ХУД	Хан-Уул дүүрэг
ӨЭМТ	Өрхийн эрүүл мэндийн төв	ХХААХҮС	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд
СБД	Сүхбаатар дүүрэг	ХК	Хувьцаат компани
СЗХ	Санхүүгийн зохицуулах хороо	ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
СЕХ	Сонгуулийн ерөнхий хороо	ХЭҮК	Хүний эрхийн үндэсний комисс
СХД	Сонгинохайрхан дүүрэг	ЭХС	Эрчим хүчний сайд
ЦАУЗБК	Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах комисс	ЭМС	Эрүүл мэндийн сайд
ШДНЦХ	Шилэн дансны нэгдсэн цахим хуудас		



Аудит хийх үндэслэл

Аудитыг Төрийн аудитын тухай хууль /2003 он/-ийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх заалтыг үндэслэн Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны “Аудитын сэдэв батлах тухай” 2019 оны 05 дугаар тогтоол, Үндэсний аудитын газрын 2020 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөөний дагуу гүйцэтгэлээ.

Аудитын зорилт

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх, аудитын дүнг УИХ-д танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдсэн.

Дээрх зорилтын хүрээнд дараах чиглэлийн дагуу аудитыг гүйцэтгэлээ.Үүнд:

- Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1¹, 3.1.2²-т заасан байгууллагууд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хамрагдаж, хуульд заасан мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн эсэх;
- Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3³, 3.1.4⁴, 3.1.5⁵-д заасан байгууллагууд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хамрагдаж, хуульд заасан мэдээллийг бүрэн мэдээлсэн эсэх;
- Хуульд заасан холбогдох байгууллага, албан тушаалтан хяналтыг хэрэгжүүлж, өмнөх аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлсэн эсэх.

Хамарсан хүрээ

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-3.1.5 дахь хэсэгт заасан хуулийн этгээдийг тус хуулийн 8 дугаар зүйлийн 8.2⁶-д заасны дагуу Төсвийн ерөнхийлөн захирагчдаас хэрэгжүүлж буй дотоод хяналтын дүн мэдээнд үндэслэн эрсдэл бүхий байгууллагыг түүвэрт хамруулан, 2019 оны санхүүгийн жилд хамаарах хугацааны Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн байдлыг шалгалаа.

Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэхдээ MNS 6817:2020 Төрийн аудит стандарт, АДБОУС 100, 400, 4000 стандартууд болон Нийцлийн аудитын түр журмыг баримтлан шалгагдагч байгууллагуудын ШДНЦХ-т байршуулсан мэдээллийг дансны хуулга, холбогдох тушаал, шийдвэр, гэрээтэй тулган шалгах, мэдээллийн сан, тайлан мэдээнд дүн шинжилгээ хийх аудитын арга зүйг ашиглаж, аудитын хөтөлбөр, горимын дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулсан болно.

Аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох мэдээ судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

¹ Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд

² Төрийн өмчит үйлдвэрийн газрууд

³ Хяналтын багц буюу түүнээс дээш хэмжээний хувьцаагч нь төр, орон нутаг болон тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд эзэмшиж байгаа компаниуд

⁴ Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, ажил үйлчилгээ гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгж, байгууллагууд

⁵ Төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгчид

⁶ Энэ хуулийн 3.1.1-д заасан төсвийн байгууллага, албан тушаалтны шилэн дансны үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлд заасны дагуу төсвийн ерөнхийлөн захирагч хэрэгжүүлнэ.



Аудитад ашигласан шалгуур үзүүлэлт

Аудитын зорилттой холбоотой дараах хууль, дүрэм, журам, зааврыг шалгуур үзүүлэлт болгон ашигласан. Үүнд:

- Шилэн дансны тухай хууль;
- Монгол Улсын 2019 оны Төсвийн тухай хууль;
- Төсвийн тухай хууль;
- Захиргааны ерөнхий хууль;
- Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль;
- Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”;
- Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”;
- Бусад холбогдох хууль, дүрэм, журам.



Үндсэн мэдээлэл

Аудитын төлөвлөгөөнд тусгасны дагуу аудитын зорилт, дэд зорилтуудын хүрээнд Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д заасан байгууллагууд ШДНЦХ-т бүрэн хамрагдаж, тэдгээр нь хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг бүрэн мэдээлж байгаа эсэх болон 8 дугаар зүйлийн 8.2-т заасан байгууллага, албан тушаалтан хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж байгаа эсэхийг нягтлан шалгасан.

Улсын хэмжээнд 2019 оны байдлаар ШДНЦХ-т нийт 7944 байгууллагын нэрээр мэдээлэл байршуулах цэс үүсэж, хуулийн хэрэгжилтийг хангах боломжтой болсныг байгууллагын төрлөөр ангилан хүснэгт 1-д харуулав.

Хүснэгт-1:

№	Байгууллагын төрөл	Байгууллагын тоо	Хуулийн хамаарах заалт
1.	Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар	5811	3.1.1, 3.1.2
2.	Төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой ХК, ХХК	104	3.1.3
3.	ТББ, Нөхөрлөл хоршоо, иргэн, аж ахуйн нэгж	1329	3.1.4
4.	Хувийн сургууль, цэцэрлэг, өрхийн эмнэлэг	700	3.1.5
Нийт		7944	

Мэдээллийн эх сурвалж: ШДНЦХ, Сангийн яамнаас ирүүлсэн хэрэгжилтийн тайлан.

Тус аудитаар улсын төсвийн 32 ТЕЗ, тэдгээрт хамаарах 266 байгууллага, аймаг нийслэлийн 22 ТЕЗ, тэдгээрт хамаарах 4087 байгууллага буюу нийт 4353 байгууллагыг түүвэрлэн ШДНЦХ-т байршуулсан мэдээллийг төсөв, санхүүгийн холбогдох баримт, нотлох зүйлстэй тулган шалгах горимыг хэрэгжүүлж, бусад 1458 байгууллага болон хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4-3.1.5-д хамаарах аж ахуйн нэгж, байгууллагын хувьд ТЕЗ-даас ирүүлсэн дотоод хяналтын дүн мэдээ болон ШДНЦХ-т байршуулсан мэдээлэлд үндэслэн дүн шинжилгээ хийж улсын хэмжээнд хуулийн хэрэгжилтийн дүнг гаргасан.

Шилэн дансны тухай хуульд заасны дагуу төсвийн удирдлагыг хэрэгжүүлсэн шийдвэр, үйл ажиллагааны ил тод байдлыг 2019 онд улсын төсвийн ТЕЗ-д болон тэдгээрт хамаарах байгууллагууд 91.5 хувь, аймаг, нийслэлийн төсвийн ТЕЗ-д болон тэдгээрт хамаарах байгууллагууд 87.9 хувь хэрэгжүүлж ажилласан байна.

Улсын хэмжээнд нэгдсэн удирдамжаар гүйцэтгэсэн тус аудитын явцад залруулах боломжтой зөрчлийг тухай бүр арилгуулж ажилласнаас гадна нийт 458 байгууллага, албан тушаалтанд 332 зөвлөмж өгч, 3 байгууллагын холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцуулах, 128 байгууллага, албан тушаалтанд зөрчил арилгуулах хугацаатай албан шаардлага хүргүүлж ажилласан.

Сангийн яамнаас “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулах санал боловсруулах үүрэг бүхий “Дэд ажлын хэсэг” томилон ажиллуулж, хууль тогтоомжийн зохицуулалтыг боловсронгуй болгох ажил хийгдэж байгаатай холбогдуулан ТАБ-аас 2016-2019 онд гүйцэтгэсэн аудитын тайлангуудад тусгасан хууль, журмын зохицуулалттай холбоотой эрх зүйн зөрчлийн жагсаалт болон бүрэн хэрэгжээгүй зөвлөмжийн жагсаалтыг уг тайлангийн хавсралт 2-т тусган дахин хүргүүлэхээр шийдвэрлэлээ.



БҮЛЭГ 1. ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН 3 ДУГААР ЗҮЙЛИЙН 3.1.1, 3.1.2-Т ХАМААРАХ БАЙГУУЛЛАГУУД МЭДЭЭЛЛЭЭ ХУУЛЬД ЗААСАН ХУГАЦАА ХОЦРООЖ БАЙРШУУЛДАГ ЗӨРЧИЛ ХЭВЭЭР БАЙНА.

1.1. Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, төрийн өмчит үйлдвэрийн газрууд хуульд заасан хугацаа хоцроож мэдээллээ байршуулж байна:

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, ТӨҮГ-ын нийт 5811⁷ цэс ШДНЦХ-т нээгдэж, хуульд заасан мэдээллийг олон нийтэд ил тод байршуулах боломжоор хангагдсан байна.

Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-3.1.2-т хамаарах байгууллагууд ШДНЦХ-т бүрэн хамрагдсан хэдий ч татан буугдсан зарим байгууллага болон хэрэгжээд дууссан төсөл, хөтөлбөрийн нэр дээрх цэсийг ШДНЦХ-аас хасаагүй бүртгэлтэй хэвээр байгаа нь системд ачаалал нэмэгдүүлэх, бүртгэлтэй байгууллагын тоон мэдээлэл зөрүүтэй гарах нөхцөлийг үүсгэж байна. Зөрчлийн мэдээллийг ТЕЗ-д хамаарах байдлаар хүснэгт 2-д үзүүлбэл:

Хүснэгт-2:

№	Хамаарах ТЕЗ-ийн нэр	Татан буугдсан байгууллага	
		Тоо	Нэр
1	МУ-ын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга	1	Иргэдийн оролцоо төсөл
2	МУ-ын Шадар сайд	4	Улаанбаатар төлөөлөгчийн газар, Онцгой байдлын албаны аврах, гал унтраах зориулалтын автомашин худалдан авах төсөл, Орон нутгийн түвшинд гамшгийн эрсдэлийг бууруулах, менежмент, зохицуулалтын чадавхыг сайжруулах төсөл, Онцгой байдлын байгууллагад агаараас аврах ажиллагаа явуулах нэгж байгуулах, нисдэг тэрэг, гал унтраах тусгай зориулалтын автомашин нийлүүлэх төсөл
3	Сангийн сайд	1	Хүний хөгжил сан
4	Хууль зүй, дотоод хэргийн сайд	1	“Монгол тамга” ТӨҮГ
5	Эрүүл мэндийн сайд	3	Глобаль сан ХДХВ, ДОХ тархалтын тогтолцоог бэхжүүлэх төсөл, Цахим эрүүл мэнд төсөл-Хятад, Гэмтэл согог судлалын үндэсний төвийн харьяа түлэнхийн төвийн барилга барих төсөл
6	Баян-Өлгий аймгийн Засаг дарга	3	Худалдан авах ажиллагааны хэлтэс, Ахмадын хороо, “Жана-Өлкэ” ОНӨААТҮГ,
7	Сэлэнгэ аймгийн Засаг дарга	1	“Төгөлдөр Ерөө” ОНӨААТҮГ
8	Өвөрхангай аймгийн Засаг дарга	2	“Арвайхээр хотын нийтийн тээвэр, гэрэлтүүлэг” ОНӨААТҮГ, Усан спорт сургалтын төв

Мэдээллийн эх сурвалж: ШДНЦХ-/reportorgs/

Мөн эрх зүйн зохицуулалт тодорхойгүйгээс нэг төсөв захирагчийн хувьд тухайн байгууллагын санхүүжилтийн эх үүсвэр бүрээр өөр өөр цэс давхар эрхлэн хөтөлдөг,

⁷ ТАБ-аас Засгийн газрын 2019 оны нэгдсэн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитад нийт 6542 төсөвт болон төрийн өмчит хуулийн этгээд хамрагдсан бөгөөд эрх зүйн зохицуулалтаас шалтгаалан орон нутгийн хөгжлийн сан болон зарим тусгай сангуудын холбогдох мэдээллийг харъяалах ТЕЗ-ийн цэс дотор байршуулдаг шалтгаалан ШДНЦХ-т 5810 байгууллагын цэс үүсгэгдсэн байна.



ШДНЦХ-ны хөгжүүлэлт хангалтгүйгээс зарим байгууллагын нэрээр давхар цэс үүсгэж ажлын ачаалал нэмэгдүүлж, холбогдох мэдээллийг мэдээлэхгүй дунд нь орхигдуулж болзошгүй нөхцөлийг үүсгэжээ. Тухайлбал:

- БСШУСС, ЭМС-ын багцаас тус тус санхүүжилт авдгаас шалтгаалан Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэн болон Уламжлалт анагаах ухааны хүрээлэн нэршлээр 2 цэс;
- Төсвөөс санхүүжилт авсан болон өөрийн орлого бүрдүүлдэг байдлаас шалтгаалан “Хэрэмт цамхаг” УТҮГ болон “Хэрэмт цамхаг-төсөв” нэршлээр 2 цэс;
- Төсвөөс санхүүжилт авсан болон өөрийн орлого бүрдүүлдэг байдлаас шалтгаалан ИНЕГ болон ИНЕГ-ын үйлдвэрлэл үйлчилгээ нэршлээр 2 цэс;
- “Цагаан шонхор” ТӨҮГ болон “Цагааншонхор” ТӨҮГ нэршлээр 2 цэс /1 цэс нь огт ашиглагддаггүй/;
- Чингэлтэй дүүргийн ахмадын амралт болон амралт сувилал нэршлээр 2 цэс /1 цэс нь огт ашиглагддаггүй/;
- Баян-Өлгийн аймгийн нэгдсэн эмнэлэг болон сум дундын эмнэлэг нэршлээр 2 цэс /1 цэс нь огт ашиглагддаггүй/;
- Өмнөговь аймгийн Авто тээврийн төв нэршлээр 2 цэс /1 цэс нь огт ашиглагддаггүй/;
- Ховд аймгийн Нийгмийн даатгалын сан нэршлээр 2 цэс /1 цэс нь огт ашиглагддаггүй/;
- Өмнөговь аймгийн Нийгмийн даатгалын сан нэршлээр 2 цэс /1 цэс нь огт ашиглагддаггүй/;
- Дундговь эм эргэлтийн сан болон Эм эргэлтийн сан нэршлээр 2 цэс /1 цэс нь огт ашиглагддаггүй/;
- Дархан-Уул аймаг Хонгор сум болон Дархан-Уул аймаг Хонгор сумын Тамгын газар нэршлээр 2 цэс /1 цэс нь огт ашиглагддаггүй/ тус тус үүсгэжээ.

Иймд ШДНЦХ-т хөгжүүлэлт хийж, бүртгэлийн давхардал, хийдлийг арилгах арга хэмжээ авч, дээрх харилцааг Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-д тусган зохицуулах шаардлагатай байна.

Аудитын төлөвлөгөөнд тусгасны дагуу улсын хэмжээнд нийт 4353 байгууллагыг түүвэрлэн ШДНЦХ-т байршуулсан мэдээллийг төсөв, санхүүгийн холбогдох баримт, нотлох зүйлстэй тулган шалгах горимыг хэрэгжүүлж, бусад 1458 байгууллагын хувьд ТЕЗ-аас ирүүлсэн дотоод хяналтын дүн мэдээ болон ШНДЦХ-т байршуулсан мэдээлэлд үндэслэн дүн шинжилгээ хийж, улсын хэмжээнд хуулийн хэрэгжилтийн байдлыг нягтлан шалгаж нэгтгэсэн дүнг хүснэгт 3-д үзүүлэв.

Хүснэгт-3:

ТЕЗ	Хамаарах байгууллагын тоо	Мэдээлбэл зохих мэдээллийн тоо	Хугацаа хоцорч мэдээлсэн тоо	Хэрэгжилт	Хугацаа хоцролт
Улсын ТЕЗ	1621	226861	32053	91.5%	14.8%
Аймаг, нийслэлийн ТЕЗ	4190	582576	84344	87.9%	12.3%
Нийт	5811	809437	116397	89.7%	13.6%

Мэдээллийн эх сурвалж: ШДНЦХ-/reportorgs/, ТЕЗ-даас 2019 оны байдлаар ирүүлсэн мэдээ болон орон нутаг дах ТАГ-уудын ирүүлсэн аудитын тайлан.


Хуулийн хэрэгжилтийн дэлгэрэнгүй мэдээллийг ТЕЗ бүрийн дундаж үзүүлэлтээр хавсралт 1-д үзүүлэв.

Нэгтгэсэн дүнгээс үзэхэд 2019 оны байдлаар улсын төсвийн ТЕЗ-дын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт дунджаар 91.5 хувь, аймаг, нийслэлийн төсвийн ТЕЗ-д болон тэдгээрт хамаарах байгууллагуудын хуулийн хэрэгжилт дунджаар 87.9 хувийн үзүүлэлттэй байна.




Улсын төсвийн ТЕЗ-дын ШДНЦХ-т мэдээлэл байршуулсан байдлын нэгдсэн дүнг график 1-д, аймаг, нийслэлийн ТЕЗ-ийн хуулийн хэрэгжилтийн нэгдсэн дүнг график 2-т тус тус үзүүлбэл:

График-1:



Мэдээллийн эх сурвалж: ШДНЦХ-/reportorgs/, ТЕЗ-даас 2019 оны байдлаар ирүүлсэн мэдээ болон орон нутаг дах ТАГ-уудын ирүүлсэн аудитын тайлан.

График-2:



Мэдээллийн эх сурвалж: ШДНЦХ-/reportorgs/, ТЕЗ-даас 2019 оны байдлаар ирүүлсэн мэдээ болон орон нутаг дахь ТАГ-уудын ирүүлсэн аудитын тайлан.



Дээрх графикуудаас үзэхэд хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-3.1.2-т хамаарах төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрууд ШДНЦХ-т хуульд заасан мэдээллийг 89.7 хувь хэрэгжүүлсэн үзүүлэлттэй байгаа ч нийт мэдээллийн 13.6 хувийг хуулиар тогтоосон хугацааг хоцроож мэдээлсэн зөрчилтэй байна.

Иймд хуулийн үйлчлэлд хамаарах байгууллага, албан тушаалтнууд ШДНЦХ-т хуулийн хугацаа хоцроож мэдээлэл байршуулдаг зөрчлийг гаргахгүй байх хяналт, хариуцлагын тогтолцоог сайжруулах, хуулийн хэрэгжилтийг хангуулах шаардлагатай.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-3.1.2-т хамаарах дээрх байгууллагууд нь мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.1⁸-д заасан мэдээллийг хуулиар тогтоосон хугацаанд тогтмол мэдээлэх зохицуулалттай бөгөөд 2019 оны байдлаар тухайн заалтын хэрэгжилтийн байдлыг нэгтгэсэн дүнг хүснэгт 4-т үзүүлбэл:

Хүснэгт-4:

Хуулийн заалт	Мэдээллийн агуулга	Нийт мэдээлэх	Мэдээлсэн	Мэдээлээгүй	
				Тоо	Хувь
6.1.1	Байгууллагын батлагдсан төсөв	5,810	4,437	1,373	23.6%
6.1.1.	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө	5,359	5,189	170	3.2%
6.1.1, 6.3.9	Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөгөө, гүйцэтгэл	4,745	4,307	438	9.2%
6.1.2, 6.1.6	Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан, тайлбарын хамт	72,118	69,169	2,949	4.1%
6.1.2, 6.1.6	Төрийн өмчийн аж ахуйн нэгж байгууллагын зорилтот түвшин, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан, тайлбарын хамт	5,411	5,219	192	3.5%
6.1.2, 6.3.1	Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөтөлбөр, зориулалтын батлагдсан төсөв, гүйцэтгэл	6,124	5,736	388	6.3%
6.1.3	Дараа жилийн төсвийн төсөл	5,810	4,410	1,400	24.1%
6.1.4	Санхүүгийн тайлан	5,810	5,064	746	12.8%
6.1.5	Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт	5,810	4,059	1,751	30.1%
6.1.5	Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан	5,211	4,596	615	11.8%

Мэдээллийн эх сурвалж: ШДНЦХ-/reportorgs/, ТЕЗ-даас 2019 оны байдлаар ирүүлсэн мэдээ болон орон нутаг дахь ТАГ-уудын ирүүлсэн аудитын тайлан.

Хүснэгтээс үзэхэд холбогдох байгууллагууд байгууллагын батлагдсан төсөв, дараа жилийн төсвийн төсөл, санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт зэргийг ШДНЦХ-т мэдээлдэггүй Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.1.3, 6.1.5-д заасныг бүрэн хэрэгжүүлээгүй зөрчил нийтлэг байна.

Мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.4⁹-д төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрууд нь төсөв, санхүүгийн холбогдох

⁸ 6.1. Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ:

⁹ 6.4. Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ



шийдвэр гаргаж, үйл ажиллагаа явуулснаас хойш тухайн мэдээллээ 7 хоногийн дотор ил тод мэдээлэхээр заасан. Уг зохицуулалтын хэрэгжилтийн нэгдсэн дүнг хүснэгт 5-т нэгтгэн харуулбал:

Хүснэгт-5:

Хуулийн заалт	Мэдээллийн агуулга	Нийт мэдээлэх	Мэдээлсэн	Мэдээлээгүй	
				Тоо	Хувь
6.4.2	Тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт	65,034	60,979	5,010	7.7%
6.4.3, 6.3.6	Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл	64,505	60,053	6,246	9.7%
6.4.4	Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг	65,206	60,549	6,743	10.3%
6.4.5	Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ	60,706	56,330	6,799	11.2%
6.4.6	Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн	65,000	60,852	5,171	8.0%
6.4.7	Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт	60,393	54,944	6,547	10.8%
6.4.8	Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр	66,119	61,397	7,671	11.6%
6.4.9, 6.10	Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдэл	61,256	57,457	4,972	8.1%

Мэдээллийн эх сурвалж: ШДНЦХ-/reportorgs/, ТЕЗ-даас 2019 оны байдлаар ирүүлсэн мэдээ болон орон нутаг дах ТАГ-уудын ирүүлсэн аудитын тайлан.

ТАБ-аас өмнө гүйцэтгэсэн 7 удаагийн аудитаар хуулийн 3.1.1, 3.1.2-т хамаарах байгууллагуудын хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-д заасан мэдээлэл тус бүрээр гарч буй зөрчил, шалтгаан нөхцөлийг тайланд дэлгэрэнгүй тусган, шаардлагатай зөвлөмжийг холбогдох байгууллагуудад хүргүүлж байсан.

Мөн тус аудитаар улсын төсвийн 32 ТЕЗ, тэдгээрт хамаарах байгууллагаас 266, аймаг, нийслэлийн 22 ТЕЗ, тэдгээрт хамаарах байгууллагаас 4087 байгууллага, албан тушаалтныг түүвэрт хамруулан, холбогдох мэдээллийг ШДНЦХ-т иж бүрэн, үнэн зөв, мэдээлсэн эсэхийг төсөв, санхүүгийн баримт, нотлох зүйлстэй тулган шалгаж хуульд заасан мэдээллийг ШДНЦХ-т мэдээлээгүй, дутуу мэдээлсэн нийт 128 байгууллага, албан тушаалтанд зөрчил арилгах хугацаатай албан шаардлага өгч шийдвэрлэсэн.

Харин Гадаад харилцааны яамны харьяа 44 дипломат төлөөлөгчийн газруудын шилэн данс хөтлөлтийн байдлыг баримттай тулган шалгах боломжгүйгээс ШДНЦХ-т мэдээлэл оруулсан байдлаар хэрэгжилтийг тооцон нэгтгэлд орууллаа.



1.2. Орон нутгийн төсөв, түүний төсвийн захирагчид шилэн дансны мэдээллийг байгууллагын мэдээллийн самбартаа байршуулах чиг үүргийн хэрэгжилтийн талаар:

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2 дахь заалтад хамаарах аймаг, нийслэл дэх 22 ТЕЗ-ын харьяа 4190 байгууллагаас 4182 нь хуульд заасан холбогдох мэдээллээ мэдээллийн самбартаа байршуулсан байна.

Харин дараах байгууллагууд хуульд ил тод байршуулахаар заасан мэдээллийг мэдээллийн самбартаа байршуулаагүй нь хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь заалтыг хэрэгжүүлж ажиллаагүйтэй холбоотой байна. Үүнд:

Хэнтий аймгийн ИТХ, Нийтлэг үйлчилгээний ОНӨААТҮГ, Хан Хэнтий чуулга, Булган аймгийн Булган сумын Ойн анги, Дорноговь аймгийн Сайншанд сумын ЕБ-ын 3 дугаар сургууль, Хүүхдийн 8, 10 дугаар цэцэрлэг, Төв аймгийн Төв Эрдэнэс ОНӨААТҮГ

Аудитад хамрагдсан байгууллагуудын мэдээллийн самбарт тогтоосон стандарт, бүтэц байхгүйгээс дотоод зохион байгуулалтыг харилцан адилгүй зохион байгуулж, иргэд, олон нийтийн мэдээлэл авах хэмжээнд ойлгомжтой байж чадахгүй байх эрсдэл үүсэж байна.

Дээрх зөрчлүүд нь аймаг, нийслэлийн төсвийн ТЕЗ-ын харьяа байгууллагууд иргэд олон нийт баталгаажсан үнэн зөв, иж бүрэн мэдээлэлтэй танилцах нөхцөл бүрдэхгүйд хүргэж байна.

Иймд байгууллагууд мэдээллийн самбартаа ил тод байршуулах мэдээллийн стандартыг холбогдох хууль, журамд тодорхой тусгах шаардлагатай байна.

1.3. Санхүү төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын хууль заасан чиг үүргийн хэрэгжилтийн талаар:

Санхүү төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1¹⁰, 6.4¹¹-д заасан мэдээллийг ил тод мэдээлэхээс гадна дараах мэдээллийг хуульд заасан хугацаанд мэдээлэх үүргийг мөн зүйлийн 6.5¹²-д заасны дагуу хүлээж, ШДНЦХ-т бүрэн мэдээлсэн байна. Тус яамны ШДНЦХ-т байршуулах мэдээллийн агуулгаар хэрэгжилтийн дүнг хүснэгт 6-д харуулав.

Хүснэгт-6:

Сангийн яамнаас ШДНЦХ-т байршуулах мэдээлэл

Хуулийн заалт	Мэдээллийн агуулга	Мэдээлэх тоо	Мэдээлсэн тоо	Хугацаа хоцролтын тоо
6.5.1.	Улсын төсөв, нийгмийн даатгалын сангийн төсөв, хүний хөгжил сангийн төсвийн орлого,	2	2	-

¹⁰ Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ:

¹¹ Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ:

¹² Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 6.1, 6.4-т заасан мэдээллээс гадна дараах мэдээллийг гаргана:



	зарлага, хөрөнгө оруулалт, төсвийн нэгдсэн үзүүлэлт /бүтэн жил, хагас жилээр/			
6.5.2.	Засгийн газрын гадаадын зээл, тусламжийн ашиглалтын улирлын мэдээлэл /улирал бүр/	4	4	1
6.5.3	Засгийн газрын гадаад, дотоод өрийн улирлын мэдээлэл /улирал бүр/	4	4	-
6.5.4	Улсын төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгаан тайлбарын улирлын мэдээлэл /улирал бүр/	12	12	-
6.5.5	Нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээ /сар бүр/	12	12	-
6.5.6	Жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл болон аудит хийсэн санхүүгийн нэгдсэн тайлан /бүтэн жилээр/	1	1	-
6.5.7	Төсвийн алдагдлыг санхүүжүүлэх зорилгоор гаргасан Засгийн газрын дотоод үнэт цаасны мэдээлэл /улирал бүр/	4	4	-
6.5.11	Хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэх зорилгоор гаргасан Засгийн газрын гадаад үнэт цаасны мэдээлэл /тухай бүр/	12	12	-
6.5.12.	Улсын төсвийн нэгдсэн үзүүлэлтийг макро эдийн засгийн үзүүлэлт, холбогдох бусад үзүүлэлтүүдтэй уялдуулсан судалгаа, тооцооны улирлын мэдээлэл /улирал бүр/	4	4	2
Хугацаа хоцроосон мэдээлэл 5.5 хувийг эзэлж байна.		55	55	3

Эх сурвалж: ШДНЦХ, Сангийн яамнаас ирүүлсэн хэрэгжилтийн тайлан.

Хуулийн 6 дугаар зүйлийн 6.5.8, 6.5.9, 6.5.10-д концессын холбогдох мэдээллийг Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага мэдээлэхээр заасан хэдий ч байгууллагын үндсэн чиг үүргээс хамааран Үндэсний хөгжлийн газрын ШДНЦХ дахь дэд цэст тус мэдээллийг байршуулж байна.


Иймд Шилэн дансны тухай хуулийн уг зохицуулалтыг Сангийн яам болон Үндэсний хөгжлийн газрын үндсэн үйл ажиллагаа, чиг үүргийн байдалтай уялдуулан нэмэлт өөрчлөлт оруулж, холбогдох журамд тодорхой тусгах шаардлагатай байна.

Шилэн дансны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3-т зааснаар ШДНЦХ-ыг Сангийн яам эрхлэн хөтлөх үүргийн дагуу хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагуудын төсөв, санхүү, худалдан авах ажиллагаанд ашигладаг бусад төрлийн систем, программ хангамжтай ШДНЦХ-ыг уялдуулан мэдээллийг шууд хөрвүүлж, хялбаршуулах ажлын судалгаа гарган, 2020 онд багтаан системийн шинэчлэлтийг хийхээр ажлын хэсэг томилон ажиллуулж байна.

Мөн Шилэн дансны системийн Мобайл программын хөгжүүлэлтийн ажлыг хэрэгжүүлж Андройд болон IOS хувилбаруудыг гарган байршуулсан байх бөгөөд хууль хэрэгжүүлэгч байгууллага, мэдээлэх албан тушаалтны оруулах боломжит бүх мэдээллийг автоматжуулах туршилтын ажлыг эхлүүлсэн байна. 2019 онд ШДНЦХ-т хандсан хэрэглэгчийн төхөөрөмжийн төрлөөр графикт 3-д үзүүлэв.



График-3:



Эх сурвалж: ШДНЦХ, Сангийн яамнаас ирүүлсэн хэрэгжилтийн тайлан.

Графикаас үзэхэд иргэд, олон нийт ШДНЦХ-т байршуулсан төсөв зарцуулах шийдвэр, үйл ажиллагааны холбогдох мэдээлэлтэй танилцдаг, мэдээлэл авдаг байдал өсөж байгааг харуулж байна.



БҮЛЭГ 2. ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН 3 ДУГААР ЗҮЙЛИЙН 3.1.4¹³-3.1.5¹⁴-Д ЗААСАН БАЙГУУЛЛАГУУД ШДНЦХ-Т БҮРЭН ХАМРАГДАХГҮЙ ХЭВЭЭР БАЙНА.

2.1. Шилэн дансны тухай хуулийн 3.1.3-т заасан ТӨОХК, ОНӨОХК-уудын хуулийн хэрэгжилтийн талаар:

Хяналтын багц буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг нь төр, орон нутаг болон тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд эзэмшиж байгаа компанид хамаарах Төрийн болон орон нутгийн өмчит хувьцаат компани-53, Төрийн болон орон нутгийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани-31, Төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувьцаат компани-9, Төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хязгаарлагдмал хариуцлагатай компани-10, Хувь нийлүүлсэн нийгэмлэг-1, нийт 104 байгууллага тус тус үйл ажиллагаа явуулж байна.

Тус компаниудын санхүүгийн тайлан хүснэгт 6-д үзүүлсэн ТЕЗ-ийн санхүүгийн тайланд нэгтгэгдэж байна.

Хүснэгт 6:

№	ТЕЗ-ИЙН НЭР	ТӨХК	ТӨХХК	ТӨОХК	ТӨОХХК	ХНН	НИЙТ
1	Зам тээвэр, хөгжлийн сайд	23	-		1	1	25
2	Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга	1		1	-	-	2
3	Сангийн сайд	2	4	-	-	-	6
4	Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд	-	11	3	8	-	22
5	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд	-	1	-	-	-	1
6	Эрчим хүчний сайд	22	2	-	-	-	24
	Нийт	48	18	4	9	1	80

Мэдээллийн эх сурвалж: ТЕЗ-даас 2019 оны байдлаар ирүүлсэн мэдээ болон орон нутаг дах ТАГ-уудын ирүүлсэн аудитын тайлан.

Мөн ОНӨХК-5, ОНӨХХК-13, ОНӨОХК-5, ОНӨОХХК-1 үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд харьяалах ТЕЗ-аар хүснэгт 7-т үзүүлбэл:

Хүснэгт 7:

№	ТЕЗ-ИЙН НЭР	ОНӨХК	ОНӨХХК	ОНӨОХК	ОНӨОХХК	НИЙТ
1	Архангай аймгийн Засаг дарга	1	1	-	-	2
2	Баянхонгор аймгийн Засаг дарга	2	2	-	-	4
3	Дархан-Уул аймгийн Засаг дарга	-	-	3	-	3
4	Өвөрхангай аймгийн Засаг дарга	-	-	1	-	1
5	Өмнөговь аймгийн Засаг дарга	-	-	1	1	2
6	Хөвсгөл аймгийн Засаг дарга	2	10	-	-	12
	Нийт	5	13	5	1	24

Мэдээллийн эх сурвалж: ТЕЗ-даас 2019 оны байдлаар ирүүлсэн мэдээ болон орон нутаг дах ТАГ-уудын ирүүлсэн аудитын тайлан.

Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-т хамаарах байгууллагуудаас “Оюу толгой” ХХК, “Хишиг-Уул” ХК, “Төв цэнгэлдэх хүрээлэн” ХХК, “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК -ийн Хангайн бүсийн салбар, “Миат” ТӨХК-ийн 6 төлөөлөгчийн газар

¹³ Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, ажил, үйлчилгээ гүйцэтгэж байгаа аж ахуй нэгж, байгууллага

¹⁴ Төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч



зэрэг 10 компани ШДНЦХ-т хамрагдаагүй, хуулийн хэрэгжилтийг бүрэн хангаагүй зөрчилтэй байна.

Мөн орон нутгийн өмчит “Суат” ХХК-ийн ШДНЦХ-ны цэс нь төсөв гүйцэтгэл, хөрөнгө оруулалт, тендер худалдан авалт гэсэн бүтэцтэй ба бусад мэдээллийг байршуулах цэсгүй дутуу нээгдсэнээс хуулийн 6.8-д заасан мэдээллийг бүрэн мэдээлэх нөхцөл бүрдээгүй байна.

Шилэн дансны тухай хуулийн 3.1.3-т заасан байгууллагын хуулийн хэрэгжилтийг ТЕЗ-даас ирүүлсэн мэдээлэл болон ШДНЦХ-т байршуулсан нэгдсэн мэдээллийн www.shilendans.gov.mn/reportorgs цахим хуудасны мэдээнд үндэслэн дүн шинжилгээ хийж, нэгтгэн дүгнэлээ.

Уг заалтад хамаарах нийт 94 байгууллага ШДНЦХ-т мэдээллээ байршуулснаас 81 байгууллагын мэдээллийг түүвэрт хамруулан шалгаж үзэхэд хүснэгт 8-т харуулсан үзүүлэлттэй байна.

Хүснэгт-8:

ШДТХ-ийн 3.1.3-т хамаарах түүвэрт хамрагдсан байгууллагын хуулийн хэрэгжилтийн талаарх биелэлт							
	ОНӨОХК	ТӨОХК	ТӨХХК	ОНӨХХК	ТӨХК	ОНӨХК	ОНӨОХК
Байгууллын тоо	4	1	7	19	37	10	3
Хэрэгжилтийн хувь	100%	88%	83%	76%	74%	66%	85%

Мэдээллийн эх сурвалж: ШДНЦХ-/reportorgs/, ТЕЗ-даас 2019 оны байдлаар ирүүлсэн мэдээ болон орон нутаг дах ТАГ-уудын ирүүлсэн аудитын тайлан.

Хүснэгтэд үзүүлснээр хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-т хамаарах дараах байгууллагууд ШДНЦХ-т бүртгэлтэй боловч хуулийн 3.2.8, 6.8.2, 6.10-т заасан мэдээллийг үнэн зөв, иж бүрэн, тогтоосон хугацаанд мэдээлээгүй зөрчил гаргасан байна. Тухайлбал:

- ✦ “Баянхонгор эрчим хүч” ЦТХХК нь худалдан авалтын мэдээлэл, хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний 4 тендерийг мэдээлээгүй;
- ✦ “Чандмань Баянхонгор” ХК худалдан авалтын мэдээллийг байршуулаагүй, хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан 6 тендер, төсөв, өмч хөрөнгө зарцуулах 3 шийдвэрийг мэдээлээгүй;
- ✦ “Цэвэр хот” ОНӨХК нь төсөв, өмч хөрөнгө зарцуулах 8 шийдвэрийг мэдээлээгүй;
- ✦ “Дархан Азза” ТӨХК нь төсөв, өмч хөрөнгө зарцуулах 14 шийдвэрийг мэдээлээгүй;
- ✦ “Дархан-Шарын гол” ТӨХК нь худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг хугацаа хоцроосон, 3 тендерийн ерөнхий мэдээллийг мэдээлээгүй;
- ✦ “Булган Азза” ТӨХК нь худалдан авах ажиллагааны тайланг мэдээлээгүй мөн Шилэн дансны цахим хуудсанд мэдээлсэн мэдээллийг байгууллагын мэдээллийн самбарт огт мэдээлээгүй; нь Шилэн дансны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7, 6 дугаар зүйлийн 6.8.1 дэх заалттай нийцэхгүй байгаа тул зөрчилд албан шаардлага хүргүүлсэн;
- ✦ “Автоимпекс”, “Авто замын тоног төхөөрөмжийн түрээс” ТӨХК шилэн дансанд бүртгэлтэй боловч холбогдох мэдээллийг огт мэдээлээгүй байна.

Иймд дээрх зөрчил бүхий байгууллагуудад хуульд заасан мэдээллийг олон нийтэд ил тод, үнэн зөв мэдээлэх зөвлөмж өгч, аудитын явцад зарим зөрчлийг арилгуулан, “Булган АЗЗА” ТӨХК, “Эрдэнэт ус ДТС” ОНӨХК, “Орхон АЗЗА” ТӨХК зэрэг байгууллагад албан шаардлага хүргүүлсэн.



2.2. Шилэн дансны тухай хуулийн 3.1.4-т заасан ААНБ-уудын хувьд хуулийн хэрэгжилт хангалтгүй хэвээр байна:

Шилэн дансны тухай хуулийн 6.9-д арван сая төгрөгөөс дээш үнийн дүнгээр улс, орон нутгийн төсөв, Засгийн газрын болон орон нутгийн тусгай зориулалтын сан, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт, санхүүжилт, Засгийн газар, түүний харьяа байгууллагаас гаргасан бонд, үнэт цаас, өрийн бичиг, баталгаагаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөр, арга хэмжээний дагуу санхүүжиж байгаа **аж ахуй нэгж, байгууллага**¹⁵ нийт төсөвт өртөг, хэрэгжилтийн явц, үе шат, зарлага, санхүүжилтийн мэдээллийг улирал бүр мэдээлж байхаар заасан.

Дээрх заалтын хүрээнд ШДНЦХ-т 37 ТББ, 54 нөхөрлөл, хоршоо, 1238 ААН, нийт 1329 хуулийн этгээдийн шилэн дансны мэдээллийн цэс үүсгэгдэж, мэдээлэл байршуулах боломжоор хангагдсан байна¹⁶.

Шилэн дансны тухай хуулийн 6.9-д аж ахуй нэгж байгууллага хөрөнгө оруулалт, санхүүжилтээ хүлээн авсан төсвийн байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбар, шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд холбогдох мэдээллийг байршуулах ба шаардлагатай гэж үзвэл олон нийтийн бусад цахим хуудас, өөрийн цахим хуудсаар давхар мэдээлж болно гэж заасан боловч мэдээлэл байршуулах хэлбэр нь www.shilendans.gov.mn хаягт байх агуулгаар хязгаарлагдан, хэрэгжиж байна.

Шилэн дансны тухай хуулийн 3.1.4-т заасан аж ахуй нэгжийн хуулийн хэрэгжилтийг Төрийн худалдан авах ажиллагааны газраас ирүүлсэн мэдээлэл болон шилэн дансны цахим хуудаст байршуулсан нэгдсэн мэдээллийн www.shilendans.gov.mn/reportorgs цахим хуудасны мэдээнд үндэслэн дүн шинжилгээ хийхэд хүснэгт 9-д тусгасан үзүүлэлтэй байна. Үүнд:


Хүснэгт-9:

Мэдээлэл байршуулсан байдал	ТББ	Нөхөрлөл, хоршоо	Аж ахуй нэгж
Мэдээлэл байршуулсан хуулийн этгээдийн тоо	37	54	1238
Мэдээлэл байршуулсан үзүүлэлт %/	16.2	46.3	30

Мэдээллийн эх сурвалж: ШДНЦХ-/reportorgs/.

ШДНЦХ-т бүртгэлтэй мэдээлэл байршуулсан ТББ-уудын 2019 оны хуулийн хэрэгжилтийн дүнг график 4-д үзүүлбэл:

График-4:



¹⁵ Шилэн дансны тухай хуулийн 3.1.4-д заасан байгууллага


¹⁶ 2020 оны 6 дугаар сарын 11-ний өдрийн байдлаар



Мэдээллийн эх сурвалж: ШДНЦХ-/reportorgs/.

ШДНЦХ-т бүртгэлтэй, 2019 онд мэдээлэл байршуулсан нөхөрлөл, хоршооны хуулийн хэрэгжилтийн дүнг график 5-т үзүүлбэл:


График-5:



Мэдээллийн эх сурвалж: ШДНЦХ-/reportorgs/.

ШДНЦХ-т мэдээлэл байршуулсан аж ахуй нэгж байгууллагын 2019 онд хуулийг хэрэгжүүлсэн байдлын дүнг график 6-д үзүүлбэл:

График-6:



Мэдээллийн эх сурвалж: ШДНЦХ-/reportorgs/.

Графикуудад үзүүлснээр хуулийн 3.1.4-д заасан аж ахуйн нэгж, байгууллагууд ШДНЦХ-т хамрагдсан байдал хангалтгүй, хуулийг хэрэгжүүлээгүй байдал хэвээр байгаа нь ААНБ-ын цэс үүсгэх, мэдээлэл байршуулах үүргийг бараа, ажил, үйлчилгээ худалдан авах гэрээнд тусгадаггүй, санхүүжилт олгосон байгууллагаас хяналт тавих, хариуцлага хүлээлгэх талаарх харилцааг хууль болон холбогдох журамд нарийвчлан зохицуулаагүйтэй холбоотой байна.

Иймд Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4-т хамаарах ААНБ-тай төсөв захирагчид гэрээ байгуулахдаа шилэн дансанд цэс нээлгэх, мэдээлэл байршуулах үүрэг, хариуцлагын талаар тусгаж үр дүнг үнэлэх, хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулах шаардлага хэвээр байна.



2.3. Төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгчид хуульд заасан мэдээллийг бүрэн мэдээлээгүй байна:

Шилэн дансны тухай хуулийн 6.9-д арван сая төгрөгөөс дээш үнийн дүнгээр төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээний дагуу хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөр, арга хэмжээний дагуу санхүүжиж байгаа **аж ахуй нэгж, байгууллага**¹⁷ нийт төсөвт өртөг, хэрэгжилтийн явц, үе шат, зарлага, санхүүжилтийн мэдээллийг улирал бүр мэдээлж байхаар заасан.

Дээрх заалтын хүрээнд ШДНЦХ-т 414 сургуулийн өмнөх боловсролын байгууллага, 108 хувийн сургууль, 178 өрхийн эрүүл мэндийн төвийн, нийт 700 байгууллагын шилэн дансны мэдээллийн цэс үүсгэгдэж, мэдээлэл байршуулах боломжоор хангагдсан байна¹⁸.

Аудитын түүвэрт хамрагдсан улсын төсвийн ТЕЗ болон тэдгээрт хамаарах 266 байгууллага нь хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.5¹⁹-д хамаарах иргэн, ААНБ-тай тухайн заалтад хамаарах гэрээ байгуулаагүй байна.

Шилэн дансны тухай хуулийн 3.1.5-т заасан аж ахуй нэгж, байгууллагын хуулийн хэрэгжилтийг ШДНЦХ-т байршуулсан нэгдсэн мэдээллийн www.shilendans.gov.mn/reportorgs цахим хуудасны нэгтгэл, дүн мэдээнд үндэслэн судалгаа, дүн шинжилгээ хийхэд дараах үзүүлэлтэй байна. Үүнд:


Хүснэгт-10:

Цахим хуудаст бүртгэлтэй байгууллагын тоо	Сургуулийн өмнөх боловсролын байгууллага	Хувийн сургууль	Өрхийн эрүүл мэндийн төв
	414	108	178
Мэдээлэл байршуулсан байгууллагын тоо	414	102	173
Мэдээлэл байршуулсан үзүүлэлт /%I	100	94.4	97.2

Мэдээллийн эх сурвалж: ШДНЦХ-/reportorgs/, ТЕЗ-даас 2019 оны байдлаар ирүүлсэн мэдээ болон орон нутаг дах ТАГ-уудын ирүүлсэн аудитын тайлан.

Төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр хэрэгжүүлэгч дээрх байгууллагууд ШДНЦХ-т мэдээлэл байршуулсан байдлын хэрэгжилтийн хувь хэмжээг график 7-д үзүүлбэл:

График-7:



Мэдээллийн эх сурвалж: ШДНЦХ-/reportorgs/.

¹⁷ Шилэн дансны тухай хуулийн 3.1.5-д заасан байгууллага

¹⁸ 2020 оны 6 дугаар сарын 11-ний өдрийн байдлаар

¹⁹ төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч.



Нийслэл дэх ТАГ-ын гүйцэтгэсэн аудитын тайлангаас жишээ болгож дурьдвал: 2019 онд нийслэлийн 8 дүүрэгт Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.5 дахь заалтад хамаарах хувийн цэцэрлэг, сургууль, ӨЭМТ-ийн нийт 643 ААНБ төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэснээс 602 ААНБ буюу 93.6% нь ШДНЦХ-т хамрагдсан байна. Дүүрэг бүрээр мэдээллийг хүснэгт 11-д үзүүлэв.

Хүснэгт-11:

Дүүрэг	ААНБ-ын тоо	Хамрагдалт	
		Тоо	Хувь
БГД	115	113	98.3%
БЗД	205	189	92.2%
СХД	62	60	96.8%
СБД	74	55	74.3%
ХУД	119	119	100.0%
ЧД	52	50	96.2%
БНД	5	5	100.0%
НД	11	11	100.0%
Нийт	643	602	93.6%

Мэдээллийн эх сурвалж: ШДНЦХ-/reportorgs/.

НД, ХУД, БНД-ийн хувьд төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч ААНБ-ууд бүрэн, ЧД-96.2, СХД-96.8%, БЗД 92.2%, БГД 98.3%-тай байгаа бол СБД-ийн хувьд хамгийн бага буюу 74.3% нь шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд хамрагджээ.

Төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч дээрх 643 ААНБ төсвөөс авсан улирал тутмын санхүүжилтийн талаарх давхардсан тоогоор 2563 мэдээллийг шилэн дансанд мэдээлэхээс 2199 мэдээлэл буюу 85.3%-ийг нь мэдээлжээ. ШДНЦХ-т мэдээлэл байршуулсан байдлыг дүүрэг бүрээр хүснэгт 12-т үзүүллээ.

Хүснэгт-12:

Дүүрэг	Байршуулбал зохих мэдээллийн тоо	Байршуулсан мэдээллийн тоо	Мэдээлсэн байдал
БГД	452	443	98.0%
БЗД	820	682	83.2%
СХД	247	239	96.8%
СБД	296	119	40.2%
ХУД	476	475	99.8%
ЧД	208	171	82.2%
БНД	20	20	100.0%
НД	44	36	81.8%
Нийт	2 563	2 199	85.3%

Мэдээллийн эх сурвалж: ШДНЦХ-/reportorgs/.



БҮЛЭГ 3. ШИЛЭН ДАНСНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ОРОН НУТГИЙН ИТХ, ИНХ ХУУЛЬД ЗААСАН ХЯНАЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛДЭГГҮЙ ХЭВЭЭР БАЙНА.

3.1. Хуулийн 8 дугаар зүйлийн 8.1²⁰ дэх хэсэгт заасан бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, иргэдийн Нийтийн Хурал холбогдох хяналтыг бүрэн хэрэгжүүлээгүй байна:

Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3-т “Энэ хуулийн 3.1-д заасан этгээдийн шилэн дансны үйл ажиллагаанд тавих хөндлөнгийн хяналтыг ...төрийн аудитын байгууллага хэрэгжүүлнэ” гэж заасны дагуу 2015 онд 2 удаа, 2016 онд 2 удаа, 2017 онд 1 удаа, 2018 онд 1 удаа, 2019 онд 1 удаа тус тус нэгдсэн удирдамж²¹-аар аудит хийж, аудитын тайланг УИХ болон Засгийн газарт хүргүүлэн, Төрийн аудитын тухай хуульд заасан холбогдох арга хэмжээг авч, хуулийн хэрэгжилтэд хөндлөнгийн хяналт тавих чиг үүргээ хэрэгжүүлж ирсэн.

Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-т “Энэ хуулийн 3.1-д заасан этгээдийн шилэн дансны үйл ажиллагаанд тавих хөндлөнгийн хяналтыг бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, иргэдийн Нийтийн Хурал... хэрэгжүүлнэ” гэж заасан байдаг.

Хуульд заасан хяналтын чиг үүргээ аймаг, нийслэл, сум дүүргийн ИТХ, баг хорооны ИНХ-аас хэрэгжүүлж ажилласан байдлыг хүснэгт 13-д үзүүлбэл:

Хүснэгт 13:

№	Аймаг, нийслэлийн нэр	Хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлсэн эсэх		
		Аймаг, нийслэлийн ИТХ	Сум, дүүргийн ИТХ	Баг, хорооны ИНХ
1	Архангай	Үгүй	Үгүй	Үгүй
2	Баян-Өлгий	Тийм	Тийм	Үгүй
3	Баянхонгор	Үгүй	Үгүй	Үгүй
4	Булган	Тийм	Тийм	Үгүй
5	Говь-Алтай	Үгүй	Үгүй	Үгүй
6	Говьсүмбэр	Үгүй	Үгүй	Үгүй
7	Дархан-Уул	Тийм	Тийм	Үгүй
8	Дорноговь	Тийм	Тийм	Үгүй
9	Дорнод	Тийм	Үгүй	Үгүй
10	Дундговь	Үгүй	Үгүй	Үгүй
11	Завхан	Үгүй	Үгүй	Үгүй
12	Орхон	Тийм	Үгүй	Үгүй
13	Өвөрхангай	Үгүй	Үгүй	Үгүй
14	Өмнөговь	Үгүй	Тийм	Үгүй
15	Сүхбаатар	Тийм	Тийм	Үгүй
16	Сэлэнгэ	Үгүй	Үгүй	Үгүй
17	Төв	Үгүй	Тийм	Үгүй
18	Увс	Тийм	Тийм	Үгүй
19	Ховд	Үгүй	Үгүй	Үгүй
20	Хөвсгөл	Тийм	Тийм	Үгүй
21	Хэнтий	Тийм	Тийм	Үгүй
22	Улаанбаатар	Үгүй	Үгүй	Үгүй
	Нийт	Тийм-10, Үгүй-12	Тийм-10, Үгүй-12	Үгүй-22

²⁰ Энэ хуулийн 3.1-д заасан этгээдийн шилэн дансны үйл ажиллагаанд тавих хөндлөнгийн хяналтыг бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, иргэдийн Нийтийн Хурал, төрийн аудитын байгууллага хэрэгжүүлнэ.

²¹ Орон нутаг дахь Төрийн аудитын байгууллагыг оролцуулан улсын хэмжээнд аудит хийх



**Мэдээллийн эх сурвалж: Орон нутаг дахь ТАГ-уудаас ирүүлсэн аудитын тайлан.*

Хүснэгтээс үзэхэд орон нутгийн хэмжээнд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн байдалд аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-аас хяналтын чиг үүргээ зохих түвшинд хэрэгжүүлээгүй, баг, хорооны ИНХ-аас хөндлөнгийн хяналт огт хийгдээгүй байна.

Дараах аймгуудын Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба хуулиар хүлээсэн чиг үүргийн хүрээнд дор дурдсан арга хэмжээг авч, ажилласан байна. Үүнд:

- ✦ Дорноговь аймгийн Санхүүгийн хяналт, аудитын алба зөрчилтэй 6 сумын 31 албан тушаалтанд хариуцлага тооцуулах саналыг хүргүүлсэн.
- ✦ Завхан аймгийн Санхүүгийн хяналт, аудитын алба 61 албан тушаалтанд хариуцлага тооцуулах саналыг хүргүүлсэн.
- ✦ Өмнөговь аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба 2018 оны 1-3 дугаар улиралд хуулийн хэрэгжилтэд хяналт хийж 96 албан шаардлага, 46 байгууллагын 97 албан хаагчдад хариуцлага тооцуулах саналыг хүргүүлсэн.
- ✦ Говьсүмбэр Санхүүгийн хяналт, аудитын алба 58 байгууллагад давхардсан тоогоор 61 хугацаатай албан шаардлага хүргүүлсэн байна.
- ✦ Увс аймгийн Санхүү хяналт, аудитын алба нь “Шилэн дансны сайтыг хэрхэн ашиглах, мэдээлэл авах” тухай мэдээлэл, тараах материал бэлтгэн “Нээлттэй хаалганы өдөр зохион байгуулж санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг иргэдэд хүргэж ажилласан байна.
- ✦ Улсын төсвийн 32 ТЕЗ-ийн хяналт, шинжилгээ, дотоод аудитын алба, газруудаас 2019 онд хуулийн хэрэгжилтийг шалгах удирдамж, төлөвлөгөө гарган, дотоод хяналтыг хэрэгжүүлж, харьяа байгууллагууддаа зөвлөмж чиглэл хүргүүлэн ажилласан байна.

Харин орон нутгийн төсвийн бусад ТЕЗ-дийн хувьд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан эсэх нь тодорхойгүй байх тул Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд дотоод хяналтыг хэрэгжүүлэх давтамж, хугацаа болон дотоод хяналтын чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй албан тушаалтанд хариуцлага тооцох эрх зүйн зохицуулалтыг бий болгох шаардлага хэвээр байна.

3.2. Өмнөх аудитудаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байна.

Төрийн аудитын байгууллагаас 2019 онд гүйцэтгэсэн “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт” аудитаар нийт 48 байгууллагад хариуцлага тооцуулах, 519 зөрчил арилгуулах хугацаатай албан шаардлага хүргүүлсэн нь 99.6 хувийн хэрэгжилттэй байна. Сүхбаатар аймгийн ТЕЗ-д хамаарах 2 байгууллага зөрчлийг арилгаагүй байсан тул Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д заасны дагуу холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцуулах тухай албан шаардлагыг дахин хүргүүлсэн.

Харин өмнөх аудитаар улсын хэмжээнд 23 байгууллагад өгсөн 119 зөвлөмжөөс 106 хэрэгжсэн, бүрэн хэрэгжээгүй 12 зөвлөмж байна.

ҮАГ-аас МУ-ын Ерөнхий сайдад 6 зөвлөмж хүргүүлснээс Шилэн дансны тухай хууль, холбогдох журмыг боловсронгуй болгох, өмнөх жилүүдэд гүйцэтгэсэн аудитын тайлангуудад тусгасан журамлах шаардлагатай асуудлуудыг судалж шийдвэрлэх ажлыг эрчимжүүлэх агуулга бүхий 1 зөвлөмж бүрэн хэрэгжээгүй байна.

Тухайн зөвлөмжийн хүрээнд Монгол Улсын Ерөнхий сайдын 2018 оны 154 дүгээр захирамжаар Шилэн дансны тухай хууль болон бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулсан хэдий ч холбогдох ажлын гүйцэтгэл хангалтгүй байна.



Мөн Сангийн сайдад 9 зөвлөмж хүргүүлсний дагуу Сангийн сайдын 2019 оны 175 дугаар тушаалаар зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг батлан ажиллаж, 90 хувийн биелэлттэй хэрэгжүүлсэн тухай явцын тайланг ирүүлсэн.

Сангийн яамны ТНБД-ын 2018 оны А/210 дугаар тушаалаар *“Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”*-д нэмэлт өөрчлөлт оруулах санал боловсруулах дэд ажлын хэсэг томилогдон, ШДНЦХ-ыг хөгжүүлэх, журмын шинэчлэлийн төслийг боловсруулах ажлыг 2020 онд хэрэгжүүлж дуусгахаар нарийвчилсан төлөвлөгөө гарган, 70 орчим хувийн гүйцэтгэлтэй ажиллаж байгаа нь ТАБ-аас гүйцэтгэсэн Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн аудитуудын нэг үр дүн юм.

Иймд өмнөх онуудад гүйцэтгэсэн аудитын тайлангуудад тусгасан хууль, журмын зохицуулалттай холбоотой, эрх зүйн зөрчил бүхий асуудлыг дээрх ажлын хэсгийн хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнд тусгуулах арга хэмжээ авч ажиллах шаардлагатай гэж үзлээ.



ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна.

1. 2019 оны байдлаар улсын төсвийн ТЕЗ-д тэдгээрт хамаарах байгууллагуудын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт 91.5 хувьтай байгаа нь өмнөх оныхоос 4.8 хувиар, аймаг, нийслэлийн төсвийн ТЕЗ-д болон тэдгээрт хамаарах байгууллагуудын хуулийн хэрэгжилт 87.9 хувьтай байгаа нь өмнөх оныхоос 1.7 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.
2. Хуулийн үйлчлэлд хамаарах байгууллага, албан тушаалтнууд ил тод байршуулах нийт мэдээллийн 14.3 хувийг хуульд заасан хугацаа хоцроосон зөрчилтэй байгаагаас үзэхэд тухайн зөрчлийг гаргахгүй байх хяналт, хариуцлагын тогтолцоог сайжруулах шаардлагатайг харуулж байна.
3. Зарим татан буугдсан байгууллага болон хэрэгжээд дууссан төсөл, хөтөлбөрийн нэр дээрх цэсийг ШДНЦХ-аас хасаагүй, 1 төсөв захирагчид хамаарах 2 нэршил бүхий давхар цэс үүсгэсэн зэргээс шалтгаалан системд ачаалал нэмэгдүүлж, бүртгэлтэй байгууллагын тоон мэдээлэл зөрүүтэй гарах нөхцөлийг үүсгэж байна.
4. Улс, орон нутгийн төсвөөс санхүүжилт авсан ААНБ-д хяналт тавих, хариуцлага тооцох эрх зүйн тогтолцоог хууль, журамд тусгах, ШДНЦХ-т мэдээлэл байршуулах, хяналт тавих үйл ажиллагааг мэдээллийн технологи, программ хангамж ашиглан хялбарчлах ажлыг эрчимжүүлэх шаардлагатай байна.
5. Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4-д заасан аж ахуйн нэгж, байгууллагын мэдээлэх үүргийн хэрэгжилтэд хяналт тавих байгууллага, албан тушаалтанд хүлээлгэх хариуцлагын талаар эрх зүйн зохицуулалтгүйгээс хөрөнгө оруулалт, ОНХС-ийн төсөл, арга хэмжээг гүйцэтгэгч ААНБ-ууд ШДНЦХ-т хамрагдалт дунджаар 10.0%-тай байгаа нь хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд иргэд, олон нийт хяналт тавих, холбогдох мэдээлэл авах боломжгүй байна.
6. Иргэд, олон нийт ШДНЦХ-т байршуулсан мэдээлэлтэй танилцаж, мэдээлэл авдаг байдал өссөн үзүүлэлттэй байна.
7. Нийслэл болон зарим аймгийн ТЕЗ-ийн дотоод хяналт, шалгалтыг хангалтгүй хэрэгжүүлж байгаа нь Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд холбогдох хяналтыг хэрэгжүүлэх давтамж, хугацаа болон хяналтын чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй албан тушаалтанд хариуцлага тооцох эрх зүйн зохицуулалтгүйтэй холбоотой байна.
8. ШДНЦХ-т мэдээлэл оруулах арга зүйг боловсронгуй болгож, эрх зүйн орчныг сайжруулах чиглэлээр төрийн аудитын байгууллагаас өмнөх жилүүдэд өгсөн аудитын зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүйгээс зарим зөрчил давтан гарсаар байна.



ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтийг үндэслэн дараах зөвлөмжийг гаргаж байна.

Монгол Улсын Ерөнхий сайдад:

1. Монгол Улсын Ерөнхий сайдын 2018 оны 154 дүгээр захирамжаар байгуулсан Шилэн дансны тухай хууль болон бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн ажлыг эрчимжүүлэх;
2. Энэхүү тайлангийн хавсралт 2-т тусгасан өмнөх аудитуудаар өгөгдсөн зөвлөмжийн дагуу холбогдох хууль, журмыг боловсронгуй болгох арга хэмжээ авах;
3. ТЕЗ-дад холбогдох мэдээллийг ШДНЦХ-т хуульд заасан хугацаанд иж бүрэн мэдээлдэг байх чиглэл зөвлөмж хүргүүлж, хуулийн хэрэгжилтийг хангуулах.

Сангийн сайдад:

1. Сангийн яамны ТНБД-ын 2018 оны А/210 дугаар тушаалаар байгуулсан *“Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”*-д нэмэлт, өөрчлөлт оруулах санал боловсруулах Дэд ажлын хэсэгт энэхүү тайлангийн 2 дугаар хавсралтад тусгасан зөвлөмжийг хэрэгжүүлэх чиглэл өгч, биелэлтийг хангуулах;
2. ШДНЦХ-т мэдээлэл ил тод байршуулах хуулийн хугацааг хянах боломжтой байдлаар системийн хөгжүүлэлтийг боловсронгуй болгох;
3. ШДНЦХ дахь татан буугдсан, давхар цэс үүсгэгдсэн байгууллагуудын нэгдсэн судалгааг гарган холбогдох цэс дэх мэдээллийг тухай бүр шинэчилж ажиллах.



Хавсралт -1:

Улсын хэмжээнд 2019 оны байдлаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нэгдсэн дүн

№	ТЕЗ-ийн нэр	Хамаарах байгууллагын тоо	Мэдээллийн тоо				Дундаж хувь
			Ил тод байршуулах	ШДНЦХ-т байршуулсан	Хугацаа хоцроосон	Хугацаа хоцроосон	
1	Архангай аймгийн Засаг дарга	171	25187	20930	5002	23.9	79.6
2	Баян-Өлгий аймгийн Засаг дарга	159	23729	20265	4256	21.0	82.2
3	Баянхонгор аймгийн Засаг дарга	189	26809	24584	4701	19.1	86.3
4	Булган аймгийн Засаг дарга	164	23915	23628	1134	4.8	97.0
5	Дархан-Уул аймгийн Засаг дарга	90	13211	12986	668	5.1	96.6
6	Дорнод аймгийн Засаг дарга	163	23430	16799	16799	28.3	71.7
7	Дорноговь аймгийн Засаг дарга	146	21131	20983	147	0.7	99.3
8	Дундговь аймгийн Засаг дарга	144	21459	20386	3342	16.4	89.3
9	Говь-Алтай аймгийн Засаг дарга	178	25156	17232	17232	31.5	68.5
10	Говьсүмбэр аймгийн Засаг дарга	50	7561	7001	852	12.2	90.2
11	Завхан аймгийн Засаг дарга	199	29145	24190	2845	11.8	85.6
12	Орхон аймгийн Засаг дарга	256	12190	11471	700	6.1	94.0
13	Өвөрхангай аймгийн Засаг дарга	192	28598	28398	199	0.7	99.3
14	Өмнөговь аймгийн Засаг дарга	176	25611	24510	1054	4.3	95.7
15	Сүхбаатар аймгийн Засаг дарга	136	20236	15764	3578	22.7	77.6
16	Сэлэнгэ аймгийн Засаг дарга	204	29683	29535	2274	35.2	67.4
17	Төв аймгийн Засаг дарга	230	33129	33063	198	0.6	99.6
18	Увс аймгийн Засаг дарга	172	24928	24579	2704	11.0	93.8
19	Ховд аймгийн Засаг дарга	163	23728	20715	3620	17.5	84.9
20	Хөвсгөл аймгийн Засаг дарга	223	31746	31302	4511	14.4	92.1
21	Хэнтий аймгийн Засаг дарга	189	27117	25788	2321	15.1	87.8
22	Нийслэлийн Засаг дарга болон Улаанбаатар хотын захирагч	596	84877	83858	6206	7.4	95.7
23	Байгаль орчин, аялал, жуулчлалын яамны сайд	90	13040	12778	1497	11.5	93.3
24	Барилга, хот байгуулалтын яамны сайд	32	4499	4276	838	18.6	88.2
25	Батлах хамгаалахын яамны сайд	84	12157	12154	742	6.1	96.9
26	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны	176	25173	24078	7150	28.4	83.6
27	Гадаад харилцааны яамны сайд	46	6664	6541	1066	16.0	91.1
28	Зам, тээврийн хөгжлийн яамны сайд	91	11021	10581	1196	10.9	92.6
29	Сангийн сайд	83	11064	10672	1885	17.0	89.7
30	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны сайд	13	1630	1558	326	20.0	87.8
31	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны сайд	214	31487	30782	5973	19.0	89.4
32	Хууль зүй, дотоод хэргийн яамны сайд	217	31227	30433	1891	6.1	95.7
33	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны сайд	67	9609	9514	2064	21.5	88.8
34	Эрүүл мэндийн яамны сайд	171	24238	23521	2617	10.8	93.1
35	Эрчим хүчний яамны сайд	45	3990	3826	245	6.1	94.9
36	Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга	20	2325	2271	491	21.1	88.3
37	Монгол улсын ерөнхий сайд	21	2649	2216	574	21.7	81.0
38	Шадар сайд	95	13460	13232	1570	11.7	93.3
39	Авлигатай тэмцэх газрын дарга	1	206	206	5	2.4	98.8
40	Монгол Улсын ерөнхий аудитор	24	3486	3372	283	8.1	94.3
41	Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга	5	573	525	142	24.8	83.4
42	УИХ-ын Тамгын газрын дарга	3	440	417	91	20.7	87.0
43	Үндсэн хуулийн цэцийн дарга	2	283	283	61	21.6	89.2
44	Санхүүгийн зохицуулах хорооны дарга	1	206	206	42	20.4	89.8
45	Сонгуулийн ерөнхий хорооны дарга	3	429	429	1	0.2	99.9
46	Төрийн албаны зөвлөлийн дарга	1	164	164	38	23.2	88.4
47	Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгч	1	194	194	13	6.7	96.6
48	Улсын ерөнхий прокурор	42	6084	6043	374	6.1	96.6
49	Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн дарга	3	416	379	70	16.8	87.1
50	Үндэсний статистикийн хорооны дарга	24	3487	3487	178	5.1	97.4
51	Хүний эрхийн үндэсний комиссын дарга	1	206	204	75	36.4	81.3
52	Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах комиссын дарга	1	206	206	26	12.6	93.7
53	Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга	42	6084	6031	529	8.7	95.2
54	Монгол банкны ерөнхийлөгч	1	164	164			99.8
ДУНДАЖ ДҮН		5810	809437	758710	116397	13.6	89.7

* Тайлбар: Монгол банк нь төсөв санхүүгийн хяналтын хувьд Засгийн газраас хараат бус байх олон улсын байгууллагын шаардлагын дагуу өөрийн байгууллагын цахим хуудаст шилэн дансны холбогдох мэдээллийг байршуулан ШДНЦХ-т холбосон байдаг тул хуульд заасан хугацаанд мэдээллээ байршуулсан эсэхийг хянах боломжгүй байдаг.



Хавсралт-2:

Төрийн аудитын байгууллагаас 2016-2019 онд хийгдсэн аудитын тайлангуудад тусгасан эрх зүйн зөрчил болон хэрэгжилт хангалтгүй зөвлөмжийн жагсаалт

Аудитын мэдээлэл	Эрх зүйн зөрчлийн агуулга	Зөвлөмжийн агуулга
Тайлангийн холбогдох линк:		http://www.audit.mn/
<p>ҮАГ-НАГ/2015/04-НА кодтой аудитаар өгсөн зөвлөмж:</p>	<p>Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2-т заасан байгууллагууд нь хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2-т заасан мэдээллийг тогтоосон хугацаанд 6.3-т заасан ангиллын дагуу мэдээлэх үүрэгтэй бөгөөд эдгээр байгууллагуудын хувьд харьяалах дээд байгууллагуудаас нь төсөв, гүйцэтгэлийг хэмжих чанарын болон тоон шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүнг нарийвчлан баталдаггүй, санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийг төсвийн бусад байгууллагуудын нэгэн адил сар тутам гаргадаггүйгээс мэдээлдэггүй байна.</p>	<p>Монгол Улсын Засгийн газарт:</p> <p>Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д заасан төсөл, хөтөлбөр, 3.1.2-т заасан ТӨҮГ харьяалах дээд байгууллага нь ТӨҮГ, төсөл хөтөлбөрийн төсөв, шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүнг дэлгэрэнгүйгээр батлах, түүнийг мэдээлэх эрх зүйн зохицуулалтыг бий болгох;</p>
	<p>Банкны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2-т заасан Банк, түүний хараат болон охин компанид хориглох үйл ажиллагаатай нийцэхгүй, Байгууллагын нууцын тухай хууль, Хувь хүний нууцын тухай хуультай зөрчилдөх, бизнесийн өрсөлдөөнд сөргөөр нөлөөлөх нөхцөл байдал үүсгэж байна.</p>	<p>Хуулиар тусгайлсан зохицуулалттай байгууллагуудын мэдээлэх мэдээллийн агуулга, стандартыг Төрийн нууцын жагсаалт батлах тухай хууль, Банкны тухай хууль, Байгууллагын нууцын тухай хууль, Хувь хүний нууцын тухай хуультай нийцүүлэн шинэчилж, шилэн дансны цахим санд байршуулах эрх зүйн орчныг боловсронгуй болгох;</p>
	<p>Холбогдох хуулиар олгож буй нэг удаагийн урамшууллыг шилэн дансанд мэдээлэх эсэх нь Хувь хүний нууцын тухай хуультай зөрчилдөж байна.</p>	<p>Салбарын хуулийн дагуу ажилтнуудад олгож буй урамшууллыг мэдээлэх асуудлыг Хувь хүний нууцын тухай хуультай нийцүүлэн шинэчлэн боловсруулах;</p>
Тайлангийн холбогдох линк:		http://www.audit.mn/
<p>ҮАГ-НАГ/2016/04-НА кодтой аудитаар өгсөн зөвлөмж:</p>	<p>Хууль, тогтоомж, гэрээний үндсэн дээр төрийн чиг үүргийг хэрэгжүүлж байгаа байгууллагуудыг шилэн дансны цахим хуудсанд бүртгүүлэх ажлыг хэрэгжүүлж байгаа боловч хуулийн энэхүү ангиллийн нарийвчилсан тодорхойлолт, тэдгээрийг бүртгэх нэгдсэн тогтолцоо байхгүй зэргээс шалтгаалан шилэн дансны нэгдсэн бүртгэлд бүрэн хамруулж чадаагүй байна.</p>	<p>Монгол Улсын Засгийн газарт:</p> <p>Төрийн чиг үүрэгт хамаарах ажил үйлчилгээг гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч байгууллага болон улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр ажил, үйлчилгээ үзүүлж буй ААНБ-ын тодорхойлолт, эрх, үүрэг, тэдгээрийг шилэн дансанд бүртгэх, мэдээлэл оруулах, хасах нөхцөл, шаардлагыг журмаар нарийвчлан зохицуулах;</p>
	Тайлангийн холбогдох линк:	
<p>ҮАГ-НАГ/2017/03-НА кодтой аудитаар өгсөн зөвлөмж:</p>	<p>Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.8.1 , 6.8.2 , 6.8.3 -т хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-т заасан ТӨҮГ “төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах аливаа шийдвэр”-ийг мэдээлэхээр заагаагүй байхад “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3 -т мэдээлэхээр зааж, хуульд</p>	<p>Монгол Улсын Ерөнхий сайдад:</p> <p>Шилэн дансны тухай хуулийг Төсвийн тухай хуульд нийцүүлэх, тайланд дурдагдсан хуульчлах шаардлагатай асуудлуудыг судалж шийдвэрлэх;</p>



	<p>заагаагүй үүрэг хүлээлгэн мэдээлүүлж байгаа нь төр, орон нутгийн өмчийн оролцоотой компанийн зах зээлд давуу байдлаа хамгаалахад сөргөөр нөлөөлөх нөхцөлийг бүрдүүлсэн байна.</p> <p>Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-т төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, 3.1.2-т төрийн өмчит үйлдвэрийн газар хуулийн үйлчлэлд хамаарахаар давхардуулсан, мөн хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т ТЕЗ-ийн дотоод хяналтыг зөвхөн энэ хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-т заасан байгууллагад хуульчилсан нь Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 , 69.3 -т нийцэхгүй байна.</p>	
	<p>Шилэн дансанд мэдээлэл тавихтай холбогдсон харилцааг зохицуулж байгаа “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга нийтлэг стандартыг тогтоох журам” нь Захиргааны ерөнхий хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 , 60.1.2 , 60.1.8 -д заасан захиргааны хэм хэмжээний актын шаардлагад нийцээгүй байна.</p> <ul style="list-style-type: none"> - Хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4, 6.5-д заасан заалтыг давхардуулан зохицуулсан; - Хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.3-т тендерийн урилгыг мэдээлэхээр заасан байхад журамд нарийвчилсан зохицуулалт тусгаагүй, нэгдсэн цахим хуудаст мэдээлэх цонх байхгүй байна. 	<p>Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ыг Шилэн дансны тухай хууль болон Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэх, тайланд дурдагдсан журамлах шаардлагатай асуудлуудыг судалж шийдвэрлэх;</p>
	<p>Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээ, ажил, үйлчилгээ гүйцэтгэж байгаа аж ахуй нэгж, байгууллага болон төрийн чиг үүрэгт хамаарах ажил үйлчилгээг гэрээний үндсэн дээр гүйцэтгэгчийн мэдээлэх үүргийн хэрэгжилтэд хяналт тавих байгууллага, албан тушаалтан, хүлээлгэх хариуцлагыг хуульд тодорхой тусгаагүйгээс дээрх байгууллагууд нэгдсэн цахим хуудаст бүрэн хамрагдахгүй байна.</p>	<p>Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4, 3.1.5-д заасан аж ахуй нэгж, байгууллагуудтай байгуулах гэрээнд шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд хуульд заасан мэдээллийг байршуулах үүргийг тусгаж, биелэлтээр санхүүжилт олгох арга хэмжээ авах.</p>
Тайлангийн холбогдох линк:		<p>https://api.audit.mn:4444/pages/a39c6799f8641e1cf0672b4f7ac5a22/watermarked.pdf</p>
<p>ҮАГ-НАГ/2018/01-НА кодтой аудитаар өгсөн зөвлөмж:</p>	<p>Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д хамаарах Хүмүүнлэгийн болон буцалтгүй тусламж, хөнгөлөлттэй зээл хэлбэрээр санхүүждэг зарим томоохон төсөл, хөтөлбөрүүдийн хувьд санхүүжүүлэгч байгууллагаас гүйцэтгэгч хуулийн этгээдэд зарим санхүүжилтийг шууд шилжүүлдгээс тухайн төсөл, хөтөлбөрийн төсвийн зарцуулалт, гүйцэтгэлийн мэдээлэл бүрэн мэдээлэгдэхгүй байгаа нь хуулийн 4 дүгээр зүйлд заасан “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх” зарчим хангагдахгүй байна.</p>	<p>Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүх танаа:</p> <p>Энэхүү тайланд зөрчилтэй асуудлыг дурдсан Хүмүүнлэгийн болон буцалтгүй тусламж, хөнгөлөлттэй зээл хэлбэрээр санхүүждэг зарим томоохон төсөл, хөтөлбөрийн төсөв санхүүгийн үйл ажиллагааг ил тод мэдээлэх зохицуулалтыг Шилэн дансны тухай хууль, тогтоомжтой уялдуулах талаар холбогдох арга хэмжээ авах;</p>



	<p>Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2.3-т Засгийн газрын тусгай сангийн “төсөв санхүүгийн үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, хэрэгжилт, тайлагнал, эдгээртэй холбоотой мөнгөн болон бусад гүйлгээ” хуулийн үйлчлэлд хамаарах ерөнхий зохицуулалтыг тусгасан. Иймд Засгийн газрын тусгай сангийн төсвөөс зээл, хөнгөлөлт, урамшуулал олгох сонгон шалгаруулалтын үйл ажиллагааг ил тод мэдээлэх зохицуулалтыг холбогдох хууль тогтоомжтой уялдуулан Шилэн дансны тухай хууль, журамд нэмж тусгах шаардлагатай.</p>	<p>Мөн тайланд зөрчилтэй асуудлыг дурдсан Засгийн газрын тусгай сангуудын төсөв санхүүгийн үйл ажиллагааг ил тод мэдээлэх зохицуулалтыг Шилэн дансны тухай хуультай уялдуулах талаар холбогдох арга хэмжээ авах;</p>
	<p>Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4, 3.1.5-д хамаарах арван сая төгрөгөөс дээш үнийн дүнгээр улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, ажил, үйлчилгээ гүйцэтгэгч ААНБ-ууд Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст бүрэн хамрагдаагүй, төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг гүйцэтгэгчид хуульд заасан мэдээллийг мэдээлээгүй нь санхүүжилт олгосон байгууллагаас хяналт тавих, хариуцлага хүлээлгэх зохицуулалтгүйтэй холбоотой байх тул уг асуудлыг хууль, журамд нэмж зохицуулах шаардлагатай байна.</p>	<p>Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3, 3.1.4, 3.1.5-д хамаарах хуулийн этгээдийн шилэн дансны үйл ажиллагаанд хяналт тавих этгээдийг оновчтой тодорхойлж, хүлээлгэх хариуцлагыг Шилэн дансны тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомжтой уялдуулах талаар арга хэмжээ авах зэрэг болно.</p>
	<p>Шилэн дансны нэгдсэн цахим хуудасны боловсруулалт, хөгжүүлэлт хангалтгүйгээс www.tender.gov.mn сайтад мэдээллийг давхардуулж байршуулдаг, мэдээлэл байршуулах цэс бусад төсөв, санхүүгийн төлөвлөх, тайлагнах загвар маягтуудтай уялдаагүйгээс мэдээллийг гараар шивж оруулдаг зэргээр ажлын хэт ачаалал үүсгэдэг, байгууллагуудын хөтөлж байгаа цэс нь зөрүүтэй үүсгэгдсэн зэрэг зөрчилтэйгөөс хуулийн 4 дүгээр зүйлд заасан “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх, мэдээлэл ач холбогдолтой байх” зарчмын хэрэгжилт хангалтгүй байна.</p>	<p>Сангийн сайд Ч.Хүрэлбаатар танаа: Шилэн дансны нэгдсэн цахим хуудсыг эрхлэн хөтлөх чиг үүргийн хүрээнд цахим хуудасны агуулга стандартыг хууль, журамд нийцүүлэн, хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагуудын төсөв, санхүү, худалдан авах ажиллагаанд ашигладаг бусад систем, программтай уялдуулан мэдээллийг шууд хөрвүүлж хялбаршуулсан байдлаар ил тод мэдээлэхээр шинэчлэн хөгжүүлэх арга хэмжээ авах; Хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д заасны дагуу баг, хороодын иргэдийн Нийтийн Хурлын хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэх арга зүйг боловсронгуй болгож, холбогдох сургалт зохион байгуулах;</p>
<p>Тайлангийн холбогдох линк:</p>		<p>https://api.audit.mn:4444/pages/c6e3a3fd7ae85ee84decc8a6701ba37c/watermarked.pdf</p>
	<p>Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 -д заасны дагуу Хөдөлмөрийн гэрээ, контракт байгуулан ажилладаг төрийн үйлчилгээний албан хаагчид Шилэн дансны тухай хуулийн дагуу холбогдох мэдээллийг байршуулах үүрэг хүлээсэн байдаг. Гэтэл тус хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-т “Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл</p>	<p>Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүх танаа: Монгол Улсын Ерөнхий сайдын 2018 оны 154 дүгээр захирамжаар байгуулсан Шилэн дансны тухай хууль болон бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийн ажлыг эрчимжүүлэх;</p>



<p>ҮАГ-НАГ/2019/01-НА кодтой аудитаар өгсөн зөвлөмж:</p>	<p>нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ” гэж зааснаас Хөдөлмөрийн гэрээ, контрактаар ажилладаг төрийн үйлчилгээний албан хаагчид Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллагаагүй тохиолдолд дээрх заалтын дагуу хариуцлага тооцох эрх зүйн зохицуулалтыг орхигдуулжээ.</p>	<p>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн байдалд 2015-2019 онуудад хийгдсэн нийцлийн аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн дагуу тус хууль болон Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудаст тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулах арга хэмжээ авч ажиллах.</p>
	<p>ШДНЦХ-ны боловсруулалт, хөгжүүлэлт хангалтгүйгээс дараах зөрчил, хүндрэлийг үүсгэж хуулийн 4 дүгээр зүйлд заасан “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх, мэдээлэл ач холбогдолтой байх” зарчим хэрэгжихгүйд хүргэжээ. Үүнд: Улс орон нутгийн бүх ТЕЗ болон түүний шууд харьяаны байгууллага нь ШДНЦХ-т тус бүртээ мэдээлэл байршуулах цэс үүсгэснээс 1 ТЕЗ-ийн төсөв зарцуулах үйл ажиллагааг 2 газарт давхар мэдээлэх хүндрэлийг үүсгэж ажлын ачаалал нэмсэн; ШДНЦХ-т тендерийн урилга байршуулах цэс үүсгээгүй орхигдуулсан; Хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт төрийн байгууллага, төрийн болон төрийн өмчит хуулийн этгээдүүд 6 төрлийн мэдээллийг хуульд заасан хугацаанд жилд 26 удаа мэдээлэхээр тусгасан байхад ШДНЦХ-т 8-10 төрлийн мэдээллийг жилд 64-ээс дээш удаа мэдээлэх цэс үүсгэж ажлын ачаалал нэмсэн; Хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсэгт төрийн байгууллага, төрийн болон төрийн өмчит хуулийн этгээдүүд 9 төрлийн мэдээллийг шийдвэр гарснаас хойш тухай бүр 7 хоногийн дотор мэдээлэхээр заасан байхад ШДНЦХ-т 10 төрлийн мэдээллийг жилд 64 удаа, 8 төрлийн мэдээллийг тухай бүр 7 хоногийн дотор мэдээлэх цэс үүсгэж ажлын ачаалал нэмсэн; Байгууллагууд 10 сая төгрөгөөс дээш худалдан авах ажиллагаатай холбоотой мэдээллийг ШДНЦХ болон www.tender.gov.mn хаягаар давхар мэдээлдгээс ажлын ачаалал үүсгэж, мэдээлэл дутуу байршигддаг.</p>	<p>Сангийн сайд Ч.Хүрэлбаатар танаа:</p> <p>Сангийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2018 оны А/210 дугаар тушаалаар байгуулсан дэд Ажлын хэсгийн ажлыг эрчимжүүлэх;</p> <p>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн байдалд 2015-2019 онуудад хийгдсэн нийцлийн аудитын тайлан, дүгнэлтийн дагуу тус хууль болон Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудаст тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулах арга хэмжээ авч ажиллах;</p>
	<p>Тайлангийн холбогдох линк:</p>	<p>https://api.audit.mn:4444/pages/fd3f7d7c45da1b6fc6967840e2f537/watermarked.pdf</p>
<p>Нээлттэй нийгэм форумаар хийлгэсэн хандалтын судалгааны тайлан</p>	<p>Нийслэлийн Баянгол, Баянзүрх, Чингэлтэй дүүргийн иргэдийн дунд хийсэн энэхүү судалгааны дүнгээр шилэн дансны нэгдсэн цахим хуудасны талаар иргэдийн мэдлэг, мэдээлэл дутмаг байгаа нь харагдав. Тухайлбал, судалгаанд хамрагдсан иргэдийн 55% нь шилэн дансыг “бага зэрэг мэднэ”, гэж хариулсан бол зөвхөн 8% нь “сайн мэднэ”</p>	<p>Судалгааны дүнгээс харахад, төсвийн удирдлагад олон нийт хяналт тавих үйл ажиллагааг дээшлүүлэхийн тулд Шилэн дансны тухай хууль болон шилэн дансны нэгдсэн цахим хуудсыг иргэдэд таниулах ажлыг төр засгийн зүгээс хийх шаардлагатай байна.</p>



	<p>гэжээ. Цаашилбал, Шилэн дансны нэгдсэн цахим хуудасны талаар иргэдийн 32.5% нь “бага зэрэг мэднэ”, гэсэн бол зөвхөн 6% нь “сайн мэднэ” гэжээ.</p> <p>Судалгаанд хамрагдсан иргэдийн зөвхөн 6% нь улс, орон нутгийн болон төсвийн байгууллагын төсвийн талаарх мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудаснаас авдаг байна.</p> <p>Шилэн дансны цахим хуудаснаас мэдээлэл авдаг иргэд мэдээлийн үнэн зөв, бодитой, иж бүрэн байдал, ойлгомжтой, ач холбогдолтой байдал, тогтоосон хугацаандаа мэдээлдэг байдал болон хуулийн дагуу нууцад хамруулсанаас бусад бүх мэдээллийг нээлттэй байршуулж буй байдалд “дунд” гэсэн үнэлгээ өгсөн байна.</p>	<p>Мөн цахим хуудсанд байршуулсан мэдээллийн ойлгомжтой байдлыг дээшлүүлэх, мэдээллээ шинэчилж, татаж авахад хялбар болгох хэрэгтэй байна.</p>
--	--	--

----- о О о -----



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ

МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
С.Данзангийн гудамж 5/1, Засгийн газрын II байр,
Утас/факс: (976-51) 26 74 68, И-мэйл: info@mof.gov.mn
Вэбсайт: www.mof.gov.mn

2020.07.02 № 13-1/4555


танай _____-ны № _____-т

Санал хүргүүлэх тухай

“Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт”-д хийсэн YAГ-НАГ/2020/01-НА дугаартай нийцлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа. Аудитын тайлангийн төсөлд тусгайлан өгөх саналгүй болно.

Шилэн дансны тухай хууль болон холбогдох журмыг боловсронгуй болгох, системд шаардлагатай шинэчлэл, өөрчлөлтийг хийхэд тус аудитын тайлангаар өгсөн дүгнэлт, зөвлөмжийг тусган хэрэгжүүлж ажиллана.

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ЭРСДЭЛИЙН
УДИРДЛАГЫН ГАЗАР




Б.ДОРЖСЭМБЭД

9761 08696



Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогчийн 2020 оны ... Сарын
 20...-ны өдрийн тоот тушаалын Хавсралт №2



Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн аудитаар өгсөн албан шаардлагын жагсаалт

№	Аудитын чиглэл	Зөрчсөн хууль тогтоомжийн зүйл заавт	Алдаа зөрчлийн товч утга	Мөнгөн дүн /сая.төг/	Нэр	Огноо	Дугаар	Зөрчил гаргасан байгууллага, албан тушаалтны Байгууллагын нэр	Албан Тушаал	Овог нэр		
1	Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллагууд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хамрагдаж хуульд заасан мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн эсэх	6.4.5, 6.10, 6.1.1, 6.3.6, 6.4.3, 6.4.4, 6.4.9, 6.10, 6.4.8.	Алдаа зөрчлийн товч утга	4	5	6	7	8	9006109	Овог нэр		
1	Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллагууд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хамрагдаж хуульд заасан мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн эсэх	6.1.6, 6.3.3, 6.4.5, 6.10, 6.1.1, 6.4.9, 6.10.	Төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбар. Үйл ажиллагааны дансны цаглингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш зарлагын гүйлгээний шийдвэрийн хуулбарыг 1-4, 7-12 сард, 100900039401 тоот намалт санхүүжилт, 100900039301 тоот хөрөнгө оруулалт, 100900037023 тоот МБСургалтыг дэмжих сангийн дансны цаглингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш дүнтэй орлого, зарлагын мөнгөн гүйлгээ, Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний төндөрийн Ерөнхий мэдээлэл, 3/78, 3/77, 3/79, 3/80, 3/82, 3/96, 3/97, 3/99, 3/100, 3/109, 3/240, 3/333, 3/334, 3/335, 3/338, 3/341, 3/342, 3/343, 3/345, 3/347, 3/349, 3/350, 3/354, 3/355, 3/357, 3/358, 3/362, 3/365, 3/376, 3/381, 3/387, 3/388 тоот гараж байгуулсан худалдан авалт, Төсөв захиран зарцуулсан ТНБД-ын 25 тушаал, Худалдан авах ажиллагааны тайлан болон Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдээллийг тус тус мэдээлээгүй.						Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	Санхүүгийн үйл ажиллагаа хариуцсан мэргэжилтэн	Л.Сансартуяа	
			Төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбар, 100900011862 тоот дансны цаглингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш дүнтэй орлогын гүйлгээ, шийдвэрийн хуулбар, 100900011933 тоот дансны 5 сая төгрөгөөс дээш дүнтэй зарлагын шийдвэрийн хуулбар, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө болон худалдан авах ажиллагааны тайланг тус тус мэдээлээгүй.							Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл	Төслийн зохицуулагч	Д.Мөнхтогтох
			Төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбар, үйл ажиллагааны дансны орлогын гүйлгээ, хагас жилийн санхүүгийн тайлан болон төсөв, мөнгө захиран зарцуулсан бүх тушаал шийдвэрийг мэдээлээгүй.						Зөрчил арилгуулах тухай	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар	Дарга Ахлах нягтлан бодогч	О.Алтөнсүх, Б.Халиун У.Батнасан
			Төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбар, 10900017407 тоот дансны цаглингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш дүнтэй орлого, зарлагын гүйлгээ, төндөрийн мэдээлэл болон төсөв, мөнгө захиран зарцуулсан А/03, А/06, А/07, А/22, А/30, А/31, А/39, А/44, А/48, А/52, А/55, А/57, А/68, А/75, А/78 дугаартай нийт 17 тушаал мэдээлээгүй.							Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар	Дарга Ерөнхий нягтлан бодогч	Б.Нямдаваа, Т.Барахбаяр Б.Оюунбилэг
		6.1.2, 6.4.5, 6.10, 6.1.1, 6.4.9, 6.10.	Төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбар, 100900011829, 100900011919 тоот дансны цаглингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш дүнтэй орлогын гүйлгээ, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан болон Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдээллийг тус тус мэдээлээгүй.					Хөдөлмөр эрхлэх үр чадварыг дээшлүүлэх төсөл	Төслийн удирдагч Б.Бямбадорж Санхүү, удирдлагын мэргэжилтэн	Б.Бямбадорж Д.Уранчимэг		



Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2 -т заасан байгууллагууд шилэн дансны нэгдсэн цэхим хуудаст хамрагдаж, хуульд заасан мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн эсэх	Төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбар, 100900011824, 100900011918, 1046000059857 тоот дансны цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш дүнтэй зарлагын гүйцэтгэлийн шийдвэр, Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ төлөвлөгөө, гүйцэтгэл, кофцесын зүйлийн жагсаалт, гүйцэтгэлийн бүтэн жилийн мэдээллийг мэдээлээгүй. Худалдан авах ажиллагааны тайланг их бүрэн мэдээлээгүй. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдээлэл болон Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний төндөрийн ерөнхий мэдээллийг мөвгтэн дагуу мэдээлээгүй.	Зөрчил арилгуулах тухай	2020.08.20	04/263	Хүнс тэжээл, нийгмийн халамжийн нэмэлт санхүүжилтийн төсөл	Төслийн зохицуулагч	Ц.Болормаа
6.1.6, 6.3.3, 6.4.5, 6.10, 6.1.1, 6.3.7, 6.3.6, 6.4.3, 6.4.9, 6.10.	Төсвийн гүйцэтгэлийн мэдээг 1, 2 дугаар сард, Төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбарыг улирал бүр мэдээлээгүй, Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлтийг 1, 3-10 сард үнэн зөв мэдээлээгүй, 100900006002 тоот дансны санхүүжилтийн орлогын гүйлтээ болон зарлагын гүйцэтгэлийн шийдвэрийн хуулбарыг мэдээлээгүй, 100900006300 тоот хөрөнгө оруулалтын дансны орлого, зарлагын гүйлтээ мэдээлээгүй, 5 аж ахуй нэгжтэй байгуулсан 38,048 мянган төгрөгийн гэрээг мэдээлээгүй, Төсөв захиран зарцуулсан ХЭГ-ын даргын Б/01, Б/02, Б/10, Б/16, А/16, А/17, А/19, А/21 тоот тушаалуудыг мэдээлээгүй.	Зөрчил арилгуулах тухай	2020.08.20	04/263	Улсын Ерөнхий прокурорын газар	Санхүү, хангамж хариуцсан референт, нягтлан бодогч	Ш.Эрдэнбилэг
6.1.6, 6.3.3, 6.4.5, 6.10, 6.3.7, 6.4.8,	Төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбарыг улирал бүр, Санхүүжилтийн орлогын гүйлтээ мэдээлээгүй, Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ төлөвлөгөө, гүйцэтгэл, кофцесын зүйлийн жагсаалт, гүйцэтгэлийн бүтэн жилийн мэдээлэл, Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний төндөрийн ерөнхий мэдээлэл, Төсөв захиран зарцуулсан А/05, А/33, А/38, А/52, А/75, А/89, А/105, А/129, А/163, А/164 тоот тушаалыг тус тус мэдээлээгүй.	Зөрчил арилгуулах тухай	2020.08.20	04/264	Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар	Дарга	Б.Чинбат
6.1.2, 6.1.3, 6.1.4, 6.1.5, 6.3.5, 6.4.8, 6.10	Дараа жилийн төсвийн төсөл бүтэн жилээр, Зорилготой түвшний гүйцэтгэл 5 удаагийн мэдээлэл, Хөндий, тусламжийн хэмжээ, түүний зарцуулалтын тайлбар хагас, бүтэн жилээр, Санхүүгийн тайлан болон тайланд хийсэн аргын дүгнэлт бүтэн жилээр, 4 тушаал, 10 гэрээ болон Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдээлэл, Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ зэргийг тус тус мэдээлээгүй.	Зөрчил арилгуулах тухай	2020.08.20	04/265	Мэдээллийн технологийн харилцаа холбооны бүх нийтийн уургийн сан	Нягтлан бодогч Дарга Нягтлан бодогч	Наранбаатар Б.Чинбат Т.Халуунаа
6.1.2, 6.1.6, 6.3.3, 6.4.5, 6.3.6, 6.4.3, 6.4.4, 6.4.8, 6.10	Төсвийн гүйцэтгэл 1-4 дүгээр улиралд, Төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбар 1-4 дүгээр улиралд, Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын 10 удаагийн мөнгөн гүйлтээ, Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний 14 төндөрийн ерөнхий мэдээлэл, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 5 төрлийн бараа, ажил үйлчилгээний нэр санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг, Байгууллагын даргын Б/01, Б/14, А/03, А/04, А/05, А/06, А/07, А/09 нийт 127.9 сая төгрөг зарцуулах тушаал, Ш/18-2019-061, V/13, V/117-1219/427, VIII/19-04, IX/22-19/503, XII/10-008, XII/13-007, XII/25-09, XII/24-11/001, XII/24-11/002, XII/09, XII/16, XII/04-Авто машин түрээс зэрэг нийт 14 удаагийн гэрээг мэдээлээгүй.	Зөрчил арилгуулах тухай	2020.08.20	04/266	Монгол Кувейтын Байгаль хамгаалах төв	Дарга Нягтлан бодогч	Д.Энхтөмөр М.Хоролсүрэн
		Зөрчил арилгуулах тухай	2020.08.20		Алал жуулчлалын хөдөлгөөн төв	Дарга	Б.Баттулга
						Нягтлан бодогч	Т.Батхүү